

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 10
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	11 – 55

1.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	12 – 53
2.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Байгал орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i>	53 – 54
3.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн удирдамж батлах тухай/</i>	54 – 55

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
10 дугаар сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 59 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Золжаргал, Б.Мөнхсоёл;

Чөлөөтэй: С.Ганбаатар, Г.Дамдинням, С.Лүндэг, Т.Мөнхсайхан, У.Отгонбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Замира, А.Ундраа.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал Б.Баттуяа, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбаяр, Шадар сайдын ажлын албаны референт Х.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Урьболд, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн орлогын хэлтсийн дарга

Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, мөн газрын Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч Ж.Алтантуяа, мэргэжилтэн С.Гэлэгжунай, Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Г.Мөнхзул, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн Р.Хангал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн О.Гантулга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бат-Өлзий, Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Э.Баттулга, Усны газрын Ус ашиглалт, технологийн хэлтсийн дарга Х.Мягмаржав, Ойн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваасүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Дэчин, Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурлыг зохион байгуулах Үндэсний хорооны дэргэдэх бэлтгэл ажлын албаны дарга Д.Батмөнх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар, Үндэсний итгэмжлэлийн төвийн дарга С.Ням-Эрдэнэ, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбаяр, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Мөнхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны референт Б.Алтан, Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Ц.Туваан, М.Мандхай, С.Одонтуяа, Ж.Батжаргал, Б.Бейсен нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун,

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч З.Цэдэнжав, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, Усны газрын Ус ашиглалт, технологийн хэлтсийн дарга Х.Мягмаржав, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Бейсен: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Хүнсний болон үрийн буудайн нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, эргэлтийн хөрөнгийн сантай болгоход зориулсан татаасыг **23,000.0 сая** төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн үг хэлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 17

Бүгд: 21

19.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд инновац нэвтрүүлэх, тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх, бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, бэлчээрийн ашиглалт, хамгааллыг сайжруулах, отрын нөөц бэлчээр, усан хангамж, өвс тэжээлийн нөөц, хангамжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулсан татаасыг **24,300.0 сая** төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 17

Бүгд: 21

19.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Сүүний урамшууллын татаасыг **13,900.0 сая** төгрөгөөр бууруулах.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн дээрх саналаа татан авч байгаагаа мэдэгдсэн тул уг саналаар санал хураалт явуулаагүй болно.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Атрын 4 дүгээр аянд зориулсан Хүнсний ногооны урамшууллын татаасыг **11,500.0 сая** төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 18
Бүгд: 21

14.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь цагаан алт хөтөлбөрийн ноосын урамшууллын татаасыг **15,600.0 сая** төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 20
Бүгд: 21

4.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь арьс ширний урамшууллын татаасыг **6,200.0 сая** төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 18
Бүгд: 21

14.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь цагаан алт хөтөлбөрийн “Бусад арга хэмжээ”-нд тусгагдсан санхүүжилтийг **600.0 сая** төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 16
Бүгд: 21

23.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн хүүгийн дэмжлэгийг **608,900.0 сая**

/133,954.0/ төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн, С.Амарсайхан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 18

Бүгд: 21

14.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **40,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **9,000.0 сая** төгрөгөөр бууруулж, “Онги-Цагаан бургастай төсөл, төслийн ТЭЗҮ, зураг төсөв, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **44,490.0 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **9,000.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 5

Бүгд: 21

76.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн нарын гаргасан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багц дахь Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт хөтөлбөрийн зардлыг **856.3 тэрбум** төгрөгөөр бууруулж, Говийг усжуулах судалгааны нэгжийн урсгал зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 5

Бүгд: 21

76.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багц дахь Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг **78,530.8 сая** төгрөгөөр

нэмэгдүүлж, энэ эх үүсвэрийг дараах төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг бууруулж болон төслөөс хасаж тооцох. Үүнд:

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2600100054 төслийн кодтой, Ерөнхийлөгчийн Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **500.0 сая** төгрөг гэсэн төсөл арга хэмжээг хасах,
- УТ2600200018 төслийн кодтой, Улсын Их Хурлын Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **3,637.5 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2601200838 төслийн кодтой Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,365.4 сая** төгрөг, санхүүжих дүн **1,064.5 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2601200355 төслийн кодтой, Цагдаагийн газрын барилга /Булган, Булган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **5,353.6 сая** төгрөг, санхүүжих дүн **1,606.1 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2601501976 төслийн кодтой, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **9,237.6 сая** төгрөг, санхүүжих дүн **2,771.3 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2601501953 төслийн кодтой, Хангайн бүсийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,126.8 сая** төгрөг, санхүүжих дүн **1,407.1 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2602800888 төслийн кодтой, Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **60,156.2 сая** төгрөг, санхүүжих дүн **18,046.9 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2602800636 төслийн кодтой, Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архустын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **170,899.7 сая** төгрөг, санхүүжих дүн **25,635.0 сая** төгрөг

гэсэн төсөл, арга хэмжээг хасах,

- УТ2603400215 төслийн кодтой, Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **8,396.8 сая** төгрөг, санхүүжих дүн **3,778.6 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2603400522 төслийн кодтой, спорт заалын барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,103.4 сая** төгрөг, санхүүжих дүн **1,396.6 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2603400239 төслийн кодтой, Спорт заалын барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,156.8 сая** төгрөг, санхүүжих дүн **970.6 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2603400052 төслийн кодтой, Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **6,728.8 сая** төгрөг, санхүүжих дүн **2,018.7 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2602900939 төслийн кодтой, Инженерийн шугам сүлжээ /Ховд, Дарви сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,792.7 сая** төгрөг, санхүүжих дүн **1,256.8 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2602900037 төслийн кодтой, Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, далан суваг /Хөвсгөл, Их-Уул сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,652.9 сая** төгрөг, санхүүжих дүн **1,643.9 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2602900572 төслийн кодтой, Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **10,407.8 сая** төгрөг, санхүүжих дүн **3,122.4 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2602900674 төслийн кодтой, Үерийн хамгаалалтын далангийн байгууламж, 5 км /Завхан, Улиастай сум, Жаргалант, Чигэстэй баг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **7,829.8 сая** төгрөг, санхүүжих дүн **3,523.4 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2606700065 төслийн кодтой, Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **14,368.5 сая** төгрөг, санхүүжих дүн **4,310.6 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2603300016 төслийн кодтой, Авлигатай тэмцэх газрын барилгын их

засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **239.5 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,

- УТ2601300963 төслийн кодтой, Цаг уурын харуулын барилга /Баян-Өлгий, Булган, Увс, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **388.3** сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах,
- УТ2601501638 төслийн кодтой, Дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Халзан сум, 1 дүгээр баг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,695.5 сая** төгрөг, санхүүжих дүн **1,213.0 сая** төгрөг гэсэн төсөл арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 14

Бүгд: 21

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байгал орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 8

Бүгд: 21

61.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 7

Бүгд: 21

66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 00 минут үргэлжилж, 30 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 59 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц 53.3 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Ирцээ танилцуулъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн, Болдын Уянга гишүүн ирсэн байна, Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна, Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна, Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна, Ренчинбямбын Сэддорж гишүүн ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна, Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Загджавын Мэндсайхан гишүүн ирсэн байна, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн байна.

Хэлэлцэх асуудал.

Нэг.Монгол Улсын 2026 онд төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай хуулиудын төсөл.

Засгийн газрын 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн. Гурав дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлэх ёстой.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай”.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай”.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй байна.

Нийгмийн бодлогын байнгын хороо давхцаж байна. Бүгд тэнд сууж байна л даа. Одоо дараагийн асуудлаа хэлэлцдэг юм уу. Н.Учрал сайдыг дуудаарай.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг,
Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Н.Учрал Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд. Одоо орж ирнэ. Хурал давхцаж байна. Б.Жавхлан Сангийн сайд, Б.Батбаатар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Үндэсний аудитын газар Ц.Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, З.Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч, Д.Энхболд Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, Б.Баттуяа Нийцлийн аудитын газрын захирал, Монгол Улсын Шадар сайдын Ажлын алба Б.Батбямба Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Х.Сүхбаатар Шадар сайдын ажлын албаны референт, Эдийн засаг, хөгжлийн яам И.Батхүү Төрийн нарийн бичгийн дарга, Л.Энх-Амгалан Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Б.Анар Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Т.Баясгалан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Б.Мөнхтөр Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, П.Чандмань Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Б.Урьболд Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Ж.Гэрэлбат Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Сангийн яам Ж.Ганбат Төрийн нарийн бичгийн дарга, М.Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэмүүлэн Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, С.Тулга Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, З.Энхболд Хууль, эрх зүйн газрын дарга, Л.Ичинноров Төсвийн орлогын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Л.Гантогтох Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ш.Бат-Эрдэнэ Хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга,

Ч.Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Р.Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Ж.Алтантуяа Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч, С.Гэлэгжунай Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Г.Мөнхзул Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Р.Хангал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн, О.Гантулга Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Ш.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Бат-Өлзий Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Т.Балжинням Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга, Г.Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Э.Баттулга Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, Х.Мягмаржав Усны газрын Ус ашиглалт, технологийн хэлтсийн дарга, Б.Ганзориг Ойн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга, Д.Даваасүрэн Санхүү, хөрөнгө оруулалт хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Д.Дэчин Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн, Д.Батмөнх Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурлыг зохион байгуулах Үндэсний хорооны дэргэдэх бэлтгэл ажлын албаны дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Ц.Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Д.Довчинсүрэн Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, З.Тулга Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, М.Дондогдорж Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, А.Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Я.Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, Стандарт, хэмжил зүйн газар. С.Батбаатар газрын дарга, Үндэсний итгэмжлэлийн төв С.Ням-Эрдэнэ Үндэсний итгэмжлэлийн төвийн дарга, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн Д.Эрдэнэбаяр гүйцэтгэх захирал, Д.Мөнхжаргал Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга.

Сангийн сайдын хурал давхцаж байгаа юм байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгыг Засгийн газрын гишүүн Ж.Энхбаяр сайд танилцуулна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулж, 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Ирэх 2026 оны төсвийн төслийг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй уялдуулан боловсрууллаа.

Төсвийн төсөлд туссан тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах онцлог арга хэмжээг дурдвал

▷ **Нэгдүгээрт**, төсвийн урсгал зардлын хувьд.

▷ Удирдах албан тушаалтны орон тоог бууруулж, төрийн албан хаагчдын нийт орон тоонд тэлэлтийг хязгаарлахын зэрэгцээ төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн байгууллагын үр ашиггүй зардлыг бууруулан хэлмэгдсэн хөрөнгийг нийгмийн салбарт зарцуулахаар;

▷ Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц 17 дугаар Бага хурлыг 2026 онд Монгол Улсад зохион байгуулах болсонтой холбогдуулан хурлын бэлтгэл ажлыг хангах, улс орноо сурталчлан таниулах, мэдээлэл түгээх, дамжуулах, соёл урлагийн арга хэмжээ зохиох, олон улсын зочид, төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах, тав тухтай орчныг бүрдүүлэх зэрэг арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэхээр;

▷ Аймаг, нийслэлийн байгалийн ургамал, ан амьтан, газар, ус, рашаан, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын эх үүсвэрээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах, хяналт тавих арга хэмжээнд зориулсан төсвийг нэмэгдүүллээ.

▷ Энэхүү нэмэгдэж байгаа хөрөнгийг орон нутгийн хөрсний доройтол, цөлжилт, ан агнуур, ховордсон амьтад, ойн үржүүлэг, усны нөөц, байгалийн дурсгалт газар, тусгай хамгаалалтын газрыг хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, судалгаа хийх, иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог дэмжих, урамшуулах, хяналт тавих, нэгдсэн сан бүрдүүлэх зэрэгт зарцуулахаар;

▷ Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилгоор 2023-2028 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулж тус салбарын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор хөнгөлөлттэй зээл олгохоор Засгийн газрын 2025 оны 255 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн.

▷ Тогтоолын хүрээнд 4 улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэхэд зориулж 6 хувийн хүүтэй 6 хүртэл жилийн

хугацаатай нийт 267.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2026 онд олгохоор тооцоолж, зээлийн хүүгийн дэмжигч зориулж 23.1 тэрбум төгрөгийг төрөөс хариуцан төлөхөөр;

► Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт уламжлалт мал аж ахуйг эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрүүдээр төрөлжиж дотоодын хэрэгцээгээ Монголын хөрсөнд ургасан эрүүл хүнсээр бүрэн хангахаар тусгагдсан.

Энэ хүрээнд “Эрүүл хүнс үйлдвэрлэгч, экспортлогч бүс” болох зорилтыг дэвшүүлж, Хүнсний хангамж, аюулгүй байдал, “Шинэ хоршоо”, “Чинээлэг малчин”, “Цагаан алт”, “Атар-4” үндэсний хэмжээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, хөдөө аж ахуйн салбарт хөнгөлөлттэй зээлийг олгож, төрөөс зээлийн хүүгийн дэмжлэг олгохоор 2026 оны төсвийн төсөлд тусгалаа.

► **Хоёрдугаарт**, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хуульд заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн иргэдээс санал авч, сум, дүүрэг, аймаг, нийслэл, салбар яамны түвшинд үе шаттайгаар төлөвлөсөн.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр нийт 14.4 их наяд төгрөгийн санхүүжих дүн бүхий 1712 төслийн санал хүлээн авснаас холбогдох шалгуур үзүүлэлт, зарчим, бодлогыг харгалзан эрэмбэлж 579 төсөл, арга хэмжээнд 3 их наяд 267.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан болно.

Нийт хөрөнгө оруулалтын 67 хувь буюу 2 их наяд 181.9 тэрбум төгрөг нь үргэлжлэн хэрэгжих бол 33 хувь нь буюу 1 их наяд 85.5 тэрбум төгрөгт шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт байна.

Энэ нь 2022-2023 онд батлагдсан төслийн тоотой харьцуулахад хоёр дахин буурсан үзүүлэлт бөгөөд төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлтийн чанар сайжирч байгааг илтгэж байна.

Түүнчлэн 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтад хүний хөгжлийг дэмжих зорилгоор боловсрол, эрүүл мэндийн салбарт бүсчилсэн хөгжил болон хувийн хэвшлийг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах хүрээнд эрчим хүч, суурь, дэд бүтцийн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор онцгой байдлын салбарт нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах үүднээс батлан хамгаалах, гадаад харилцаа, Хууль зүй, дотоод хэргийн салбарт шинэ хөрөнгө оруулалтыг түлхүү төлөвлөсөн.

Тухайлбал, тус Байнгын хороонд хамаарах салбар буюу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцад 249.6 тэрбум төгрөг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 47.8 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан.

Мөн олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын “COP17” хурлыг зохион байгуулах шаардлагатай санхүүжилт болон гадаад зээл, тусламжийн төслүүдийн Монголын талын хариуцах хөрөнгийг төсвийн төсөлд тусгалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 31.6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь зарлага 29.6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2 их наяд төгрөгийн ашигтай буюу дотоод нийт бүтээгдэхүүний 2 хувь байж улсын төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн хангахаар байна.

Иймд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагчаас асуух асуултаас гишүүд нэрс өгнө үү? Ц.Туваан гишүүнээр тасаллаа. Г.Ганбаатар гишүүний асуулт асууя.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Сая сайдын танилцуулж байгаа мэдээ дотор ч гарч л байна. Цөлжилттэй тэмцэх төсөл хөтөлбөр гээд.

Тэгээд энэ Байгаль орчин хөдөө аж ахуйн байнгын хороон дээр нөгөө говийн бүс рүү ус татах асуудал маань юу болж байгаа вэ? Үндсэндээ улс орны эдийн засгийн ачааны хүндийг говийн бүс үүрээд л байдаг. Эргээд энэ уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд хамгийн их өртэй л байдаг. Тэгсэн мөртлөө энэ дээр нь мөнгө тавьдаггүй. Бас монгол төрийн залгамж халаа гэж нэг юм байх ёстой.

Уг нь өнгөрсөн хавар өмнөх Засгийн газар говийн бүсийг усжуулах чиглэлээр Онги, Цагаанбургастайн далан, энэ чиглэлийн ажлуудыг овоо эхлүүлээд явж байсан. Одоо төсөв байдаггүй. Энэ чиглэлээр яг юу хийе гэж байгаа юм? Өнөөдрийн хуралд зарчмын зөрүүтэй 11 саналын нэгэнд бид оруулж байгаа. Гэлээ гээд тэр бол зөвхөн Онги, Цагаанбургастайн далантай л

холбоотой асуудлын дөнгөж эхлэл болохоос биш бусад ажил нь ерөөсөө явж байгаа юм алга байна шүү дээ. Нэг л гоё гоё юм яриад байдаг.

Өнгөрсөн Засгийн газар нөгөө 14 мега төсөл гээд л говийг усжуулна гээд. Дээрээс нь ахиад “Эрдэнэс Оюу Толгой” нэг тендер зарлаад говийн бүс дээр Хэрлэн голын ТЭЗҮ-г ахиад шинэчлээд хийж байгаа. Тэр нь ч бас нэг олигтой бүтэлтэй ч юм болж байгаа ч юм уу, үгүй ч юм уу.

Тэгээд говийг усжуулах нэгж гээд байгуулсан. Говийг усжуулах нэгжийг байгуулаад овоо явж байсан. Сүүлдээ тэр төсөв мөнгийг нь цалинг нь хүртэл өгөхгүй байгаа бололтой тухай тэрийг удирдаж байсан бүрлээ чинь түрүүн нөгөө цөлжилтийн төсөв гээд манай Л.Мөнхбаясгалан гишүүний ярьсан юун дээр ярьж байсан шүү дээ. Одоо энэ чиглэлээр одоо тэгээд Та бүхэн энд бид яриад нэмж хийгдэж байгаа ажлууд байна уу? Хэн нь хариулах вэ? Байгаль орчны яамнаас уу?

Б.Бейсен: Байгаль орчны сайд хариулъя. Б.Батбаатар сайд.

Б.Батбаатар: Говийн бүсийг усжуулах асуудлаар төсөв дээр мөнгө тавигдаагүй алдагдсан. Саналуудыг явуулсан.

Тэгээд бид одоо яг үнэндээ төсвийн дутагдлаас шалтгаалаад энэ асуудал дээр нэгдсэн төсвөөс мөнгө байхгүй боловч гаднын төсөл, хөтөлбөр, дээрээс нь “COP17”. Үүнтэй холбоотойгоор нэлээн бэлтгэл хангаж ажиллаж байгаа зүйлүүд байгаа. Зарим нэг амлалт, зарим нэг эхний санамж бичгүүдийг гаднын байгууллагуудтай хийсэн зүйл байгаа.

Их Хурлын гишүүд төсөв дээр говийн усжуулалтын тэр төсөв мөнгө, ТЭЗҮ зохион байгуулах, бусад зүйлүүд дээр нь мөнгө тавья гээд хамтарч ажиллаж байгаа зүйлүүд бас байж байгаа.

Тэгэхээр энэ чиглэл рүү орно доо. Тэгээд яг одоо бол тэр өргөн барьсан Засгийн газрын төсөв дээр олигтой мөнгө байхгүй дээ. Байвал одоо хэд байгаа билээ. 300 сая байгаа билүү. Тийм байгаа байх аа.

Б.Бейсен: Г.Ганбаатар гишүүнд тодруулъя.

Г.Ганбаатар: Үгүй ээ, харин ийм хариуцлагагүй байгаа байхгүй юу. Хамаг энэ улс орны эдийн засгийг чинь хамаг уул уурхайг нь говиос одоо тэр Оюу Толгой, Тавантолгой ерөөсөө л бүх л улс орны эдийн засгийн ачааг говь л үүрч явна шүү дээ.

Тэгээд эргээд энэ чинь ганцхан говийн бүсийг усжуулах гээд байгаа юм чинь биш. Энэ улс орны эдийн засагт дахиад хэрвээ усан хангамжийн бүс нутаг

дутагдалтай энэ бүс нутгийг, дээрээс нь боловсруулах үйлдвэрлэлүүдийг усаар ханга юм бол эргээд дотоодын нийт бүтээгдэхүүн 5 хүртэлх хувиар өсөхөөр эдийн засгийн тооцоо байгаа байхгүй юу.

Тэгээд ямар ч хариуцлага байхгүй. Төсөв хэлэлцээд явж байгаад зөндөө ярьсан. Түрүүчийн Байнгын хороон дээр ярьсан. Тэгээд яах вэ, өнөөдөр энэ дээр бид зарчмын зөрүүтэй санал орж ирнэ. Та бүхэн тэр яамд хооронд нь гүйхэд нь ядаж тэр 10 гаруй тэрбум байгаа байх аа. 9 тэрбум байгаа билүү. Тэрийг дэмжээд өгчхөөрэй.

Хоёр дахь асуулт байна. Цагаа нэмээд... /минут дуусав/

Б.Бейсен: Г.Ганбаатар гишүүн 1 минут сунгая.

Г.Ганбаатар: Энэ Дорноговь аймгийн Айраг суманд Цагаандэлийн агуй гэж бий. 1960-аад оны үед жоншны уурхайн юунаас үүссэн. Монгол Улсын хамгийн том агуй.

2011 онд би Дорноговь аймгийн хурлын дарга байхдаа 2011 онд, 2014 онд аймгийн тусгай хамгаалалтад авч газрыг нь өргөтгөсөн. Хүсэлт явуулж байгаад 2019 оны 5 сард Улсын Их Хурлын тогтоол гарсан. 6 жил болсны дараа сая 9 сарын 24-нд үндсэндээ Засгийн газрын тогтоол гарсан байна. 106 дугаар тогтоол.

Тэгээд энэ хүрээнд хийгдэж байгаа ажил байдаггүй. Байгалийн нөөц болон дурсгалт газрын хил тогтоох тухай Засгийн газрын 106 дугаар тогтоол гарсан.

Эндээс тэр уул уурхайн сөрөг төлөөллийг нь багасгах ажилд анхаарах, тэр агуйн менежментийнх нь төлөвлөлтийг хийх. Тэгээд тусгай хамгаалалттай газар нутгийнхаа чиглэлээр хилийнх нь заагийг өргөтгөх чиглэлээр Байгаль орчны яам бас нэг жоохон анхааралтай ажиллахгүй бол улсын тусгай хамгаалалтад аваад 6 жилийн дараа Засгийн газрын тогтоол гарч байна шүү дээ. Б.Батбаатар сайд аа. Та үүн дээр нэг анхаараад өгөөрэй.

Б.Бейсен: Б.Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: Тийм тийм. Анхаараад ажиллаж байж 8 удаа Засгийн газар луу оруулаад батлагдаагүй байсан зүйл сая дөнгөж Засгийн газрын тогтоол болсон шүү дээ. 5, 6 жилийн хугацаанд. Тийм.

Тэгэхээр өмнөх цаг хугацаанд батлагдаагүй зүйлүүд харин энэ Засгийн газрын үед бас урагшилж эхэлж байгаа. Тийм болохоор үүн дээр анхаарч байгаа гэдгийг хэлье.

Дээрээс нь бид тэр 3 хөв цөөрөмд устай холбоотой хэлж байгаа говийн бүсийн гэдгээр. 3 хөв цөөрөмд 3.1 тэрбум байсан байх аа. Мөнгө тавигдсан. Ер нь усан дээр 347.0 сая төгрөг байгаа. Энэ мөнгө бол хаанаа ч хүрэхгүй гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа.

Азийн хөгжлийн банкнаас 51.0 сая ам.долларын санхүүжилтийг 333 нуур гэдэг концепцын дагуу авахаар ажиллаж байна. Тэгээд... /минут дуусав/

Б.Бейсен: Б.Батбаатар сайдад минут өгье.

Б.Батбаатар: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар томилогдсоноос хойш ус болон хүлэмжийн хийн асуудал дээр илүү их ач холбогдол өгч анхаарч ажиллаж байгаа гэдгийг хэлмээр байна.

Б.Бейсен: Тэр усны газар, Ус ашиглалт технологийн хэлтсийн дарга Х.Мягмаржав байна уу?

Г.Ганбаатар гишүүний асууж байгаа тэр говьд ус татах асуудал дээр тэр усны голдирол, нуур цөөрөм үүсэх талын асуудлаар хийсэн газрын кадастрын судалгаа бий юу? Энэ дээр. 7 номер. 7 номер микрофон.

Х.Мягмаржав: Өдрийн мэндийг хүргэе. Х.Мягмаржав Усны газрын Ус ашиглалт, технологийн хэлтсийн дарга.

“Орхон-Онги” төслийн хүрээнд “Орхон-Онги” төслийн ТЭЗҮ 2020 онд хийгдсэн. Одоо “Онги-Цагаанбургастай” төслийг эхний ээлжид явуулахаар судалгааны нэгж байгуулагдаад том ажлын хэсгээс үүрэг даалгавар өгөөд, энэ дээр ингээд нийт ажлууд төлөвлөөд судалгааны нэгжээс 14.0 тэрбум төгрөгийн төслийг 2026 оны төсөвт өгсөн боловч одоо үүнээс 9 тэрбумыг батлуулахаар явж байгаа.

Тэгээд энэ дотор юу орж байгаа вэ гэхээр яг “Онги-Цагаанбургастай” төсөл дээр тодотгол хийх, өөрөөр хэлбэл ус дамжуулах... /минут дуусав/

Б.Бейсен: 7 номер гэж цааш хариулъя.

Х.Мягмаржав: Тийм ажлуудыг хийхээр тусгасан байгаа. Тэгээд 2026-2030 оны үндсэн чиглэлд бас энэ асуудлуудыг тусгаад явж байгаа.

Б.Бейсен: Ц.Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Төсвүүдийг манай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо харьяалагдах яамдынхаа төсөвтэй танилцсан. Тэгээд эндээс тодруулж асуух хоёр, гурван зүйл байна. Хөдөө аж ахуйн салбар татаас урамшуулалгүй бол бас явдаггүй. Дэлхийд ийм жишиг байгаа.

Тэгэхээр энэ урамшууллууд дээрээс сүүний урамшуулал, манай сүү бэлтгэж байгаа яг энэ эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа Төв, Дархан, Сэлэнгийн бүсээс маш олон фермерүүд хэлж байна л даа. Өвс байхгүй. Энэ жил ган болсон. Дээрээс нь тэжээлийн үнэ маш өндөр байна. Хивэгний үнэ ойрхон хоёр ч удаа нэмэгдлээ.

Тэгэхээр сүүний урамшууллаа ахиулаад энэ үр дүнд хүрч байгаа. Ирэх жил бол 13.9 тэрбумыг тавьсан байна. Энэ дээр нэг асуудал байгаа. Яг тэр элгэн цаг буюу 4 сарын 01-нээс 5 сарын 01-ний хооронд бас л яг ногоо ургаагүй энэ цаг үе дээр сүүний урам тушууллаа нэмээд явах, бодлогоо ахиулаад явах боломж нэмж өгөөч ээ гэдэг саналыг маш их тавьдаг.

Тэгэхээр энэ дээр нэмэгдүүлэх бодлого боломж байгаа юу? Үүнийг ер нь яаж үзсэн юм бэ гэдэг нэг асуудал.

Дахиад л ган болсон. Улаан буудай тэжээлийн таримал, хүнсний ногоо бүгд ургац алдсан. 100 хувь хангаж байсан таримлууд хүртэл буураад ороод ирсэн. Саяын цас ч гэсэн нэлээн л асуудал үүсгэлээ.

Тэгэхээр энэ дээр би нэг зүйлийг яриад байгаа. Тэгэхээр энэ дээр одоо хэлэлцүүлгийн үед боломж гарвал нэмэгдүүлмээр байна. Тэр нь юу гэхээр ургац алдсан байгаа. Ирэх жил бид улаан буудайн урамшуулал дээр 16 тэрбум төгрөг, хүнсний ногооны урамшуулал дээр 11.5 тэрбум төгрөг тавьсан. Эндээ хүрэхгүй. Тодорхой болсон. Ургац алдсан учраас энэ дээр энэ дайны урамшууллыг авах улаан буудай, хүнсний ногоо байхгүй.

Тэгэхээр өндөр төсөвлөгдсөн энэ зүйлээ яг энэ салбарт ажиллаж байгаа зээл авсан, ургацаа алдсан, төлж чадахгүй байгаа хүмүүсийн зээлийг хойшлуулах, хүүгийн татаас руу оруулах гэдэг энэ ажиллагааг би бас нэлээн хэдэн удаа ярьж байгаа.

Тэгэхээр энэ дээр ямар боломж байна. Хэрвээ боломж байвал энэ дээр тэртээ тэргүй ургаагүй, аваагүй ургац дээр илүү мөнгө тавьж байхаар энэ мөнгийг хүүгийн татаас руу оруулаад явбал ямар вэ? Тэртээ тэргүй энэ бол онцгой нөхцөл байдал үүссэн асуудал байгаа.

Тэгэхээр үүнийг шийдмээр харагдаж байгаа юм. 1 минутаа нэмээд авъя. Дарга аа.

“Цагаан алт” хөтөлбөр дээр...

Б.Бейсен: Ц.Туваан гишүүнд 1 минут нэмээд олгоё.

Ц.Туваан: 99.5 тэрбум төгрөг байна. Зээлийг нь харахаар 2025 онд 432.8 тэрбум төгрөгийн зээл олгогдсон. 2026 онд 495 тэрбумын зээл олгогдохоор.

Ингээд энэ 900 гаруй тэрбум төгрөг болж байгаа юм. 10 хувь нь гэхээр 92 тэрбумын дотаци, хүүгийн урамшуулал олгогдохоор харагдаж байгаа юм.

Тэгэхээр энэ яагаад энэ тоо зөрүүтэй байна аа? Би эсвэл буруу хараад байна уу? Өгсөн цаас дээр нэг ийм асуудал байна.

Говийн усан дээр хэдүүлээ юу яая аа, одоо энэ зарчмын зөрүүтэй санал нь ороод ирвэл дэмжье. Энэ Л.Мөнхбаясгалан, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Сэддорж, Р.Эрдэнэбүрэн, Н.Наранбаатар гээд говиос сонгогдсон гишүүдийн асуудал биш шүү дээ. Энэ Монгол Улсын асуудал шүү дээ.

Сайдаас нэг тодруулахад төслийн нэгжээс нь төсөвт тусгуулах санал орж ирээгүй гэж байсан. Өнөөдөр дахиад энэ мөнгө ингээд тусгагдаагүй байна.

Тэгэхээр одоо зарчмын зөрүүтэй саналыг нь хэдүүлээ дэмжээд явъя гэсэн ийм нэг санал хэлье ээ. Тэгээд асуултдаа хариулт авъя.

Б.Бейсен: Байгаль орчин сайд хариулах уу? Хөдөө аж ахуйн сайд Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Хүнсний хувьсгал, хүнсний аюулгүй байдал зорилтын хүрээнд 19 нэр төрлийн барааг дотоодоосоо бүрэн хангах ийм зорилттой. Түүний нэг нь сүү байгаа.

Өнөөдрийн байдлаар бид дотоодоосоо дөнгөж 60 хувь хүрч байна.

Ц.Туваан гишүүний хэлдэг улирлын чанартай нэмэгдэл 37 үйлдвэр, цех хамрагдаж байгаа. 37 үйлдвэр, цехэд тушаагдсан сүүнд тодорхой цагтай литр тутамд мянган төгрөгийн дэмжлэг үзүүлж байгаа.

Энэ маань өөрөө их том хөшүүрэг болоод сүүлийн үед сүүний аж ахуйнууд, сүүний фермүүд, ашиг шимт малын тоо толгой нэмэгдүүлэх гээд энэ чиглэлээр нэлээн томоохон ахицууд гарсан.

Энэ бодлогыг бид бүр гүйцээх хэрэгтэй байна. Одоо байгаа батлагдсан төсөв маань хаанаа ч хүрэхгүй байгаа. 13.9 бол багадаж байгаа. Яагаад сүүнд ач холбогдол өгөөд байна гэвэл 70 сая малтай мөртлөө бид сүүнийхээ 40, 50

хувийг импортоор хангасан хэвээрээ байгаа. Нөгөө талаар сүүтэй холбоотойгоор хүүхдүүдийн шүдний өвчлөл, ясны сийрэгжилт гээд суурь өвчин үүсэж байгаа шалтгаан сүүний хангамж дутагдалтай холбоотойгоор ийм дүн шинжилгээнүүд нь гарч ирээд байгаа.

Тэгэхээр сүүний хэрэглээг ялангуяа хот суурин газрын хүн амын сүүний хэрэглээг эрс нэмэгдүүлэх шаардлага байна.

Тэгэхээр энэ бодлогыг үргэлжлүүлэх хэрэгтэй. Ц.Туваан сайдын салбар мэддэг хүний бодлоготой бид салбар нэг бодолтой байгаа. Харамсалтай нь батлагдсан эх үүсвэрүүд хүрээнд бид хязгаарлагдаад байна.

Таны тэр шилжүүлэх асуудалтай холбоотойгоор хүнсний ногооны ургалттай холбоотойгоор ногоонд өгч байгаа зарим эх үүсвэрийг сүү рүү шилжүүлье гэсэн ийм дотоод бодол байгаа.

Одоо баланс гараад дуусаж байна. Үүнтэй холбоотойгоор бид хооронд нь шилжүүлээд ер нь сүүгээ нэлээн түлхүү болгоё. Сүүгээ дотоодоосоо 100 хангах бүрэн бололцоотой. Нийт 25 мянган саалийн ашиг шимт үнээтэй болсон нөхцөлд манайхан сүүгээ бүрэн хангаад, сүүн бүтээгдэхүүн дотор хангах юм. Тэгээд энэ зорилтдоо уялдаад явж байгаа юм.

Тэгээд харамсалтай нь энэ бүх мөнгийг хасах гэдэг л саналууд байнга орж ирж байгаа. Сая зарчмын зөрүүтэй ахиад л хасъя гэдэг санал орж ирж байна. Сүүний урамшууллыг хасна л гэж байна. Үүний цаана чинь мянга мянган фермер малчдын, дээрээс нь Улаанбаатар хотын сүүний үйлдвэрүүд, дотоодын хангамж, хүн амын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал гээд олон асуудал байгаа гэдгийг санал гаргаж байгаа гишүүдэд хандаж хэлэхийг хүсэж байна.

Ургацтай холбоотойгоор 7 аймаг, 29 сум, 256 аж ахуйн нэгжийн 57.0 тэрбум төгрөг хойшлуулах хүсэлт ирсэн байгаа. Бүх судалгаагаа аваад дууссан. Онцгой байдлын гангийн нөхцөл байдлыг гамшгийн хүрээлэн дүн шинжилгээ нь гарсан.

Тэгэхээр бид зээлийн хүү, татаас өгөх бололцоо байхгүй. Хуулиар хязгаарлагдана. Харин үндсэн зээлийн төлөлтийг нэг жил хойшлуулах гэдэг ийм асуудлыг Засгийн газраар оруулж шийдүүлэхээр бид ажиллаж байна. Аж ахуйн нэгжүүд авсан зээлийнхээ хүүг төлнө. Энд ямар нэгэн төсвийн мөнгөөр авсан зээлийн хүү, татаас өгөх бололцоо байхгүй гэдгийг хэлье. Өөр. Юу байлаа. ийм л зүйлүүд байна даа.

“Цагаан алт”-ын зөрүүг манай санхүү 8 номер хариулаадах. Гайгүй байх аа. Тэр зөрүүг барих юм байхгүй.

Б.Бейсен: 8 номерын микрофон. Ц.Болорчулуун дарга.

Ц.Болорчулуун: Ц.Туваан гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун.

Тэгэхээр ирэх жилийн төсөв дээр “Цагаан алт” хөтөлбөр дээр 98 тэрбум төгрөг тусгасан байгаа. Өнөөдрийн байдлаар яг “Цагаан алт” хөтөлбөр 473.0 тэрбум төгрөгийн зээл гараад байна. Одоо 200 гаруй тэрбум төгрөгийн зээл судалгаанд байгаа. Тэгээд он дуустал тодорхой хэмжээнд гарна.

Тэгэхээр энэ 500 гаруй тэрбум төгрөгийнхээ татаасыг өгөөд үлдэгдлээр нь ирэх жил бас тодорхой хэмжээнд 450 орчим тэрбум төгрөгийн зээлийг нэмж олгоно гэсэн байдлаар тусгаж байгаа. Энэ дээр нэг их зөрүү гарахгүй байх гэж тооцоолж байгаа.

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Гишүүдийн анхааралд энэ “Цагаан алт” хөтөлбөртэй холбоотойгоор энэ онд бид их томоохон амжилт гэдэг юм уу, салбарт боловсруулалт үйлдвэрлэлийн их том түвшин ахисан.

Бид түүхий ноолуур экспортлохоо больсон. 100 хувь угааж самнасан ноолуурыг Монгол Улс экспортолдог болсон. Үүнтэй холбоотойгоор 200-аад сая долларын нэмүү өртөг Монголын дотоодыг зах зээл, дотоодын үйлдвэрлэлд нэмүү өртөг болж үлдэж байгаа.

Энд бид энэ байгаа эх үүсвэр, одоо энэ яригдаж байгаа эх үүсвэр бол ирэх хаврын ноолуур худалдан авалтад үйлдвэрүүдэд очих ёстой. Үйлдвэрлэлийн шугам 100 хувь хүчин чадал суурилагдаж дууссан. Одоо ингээд эргэлтээ бид дотоодоо хангаад эхлэхэд манай ноолуурын салбарт нэлээн их өндөр өгөөж, эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл их нэмэгдэж байгаа.

Хагас жилийн мэдээгээр манай боловсруулах салбарт 44 мянган ажлын байр шинээр бий болсон. Статистикийн хорооны мэдээ гарсан байна лээ. Хөдөө аж ахуйн салбарын боловсруулах үйлдвэрийн бодлогын манай... /минут дуусав/

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Их Хурлын баталсан “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал”, “Атрын-4” гэсэн хөтөлбөрүүдийн үр дүнд салбарын өсөлт их өндөр гарч байгаа.

Хагас жилээр Монгол Улсын эдийн засаг 5.6 хувь өссөн. Дотоодын нийт бүтээгдэхүүн. Үүний 3.6 хувийг нь хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар

дангаараа бүрдүүлж байгаа буюу хамгийн их ажлын байр бий болгож байна. Баялгийн хуваарилалт хамгийн сайн хийгдэж байна. Экспорт эрчимтэй нэмэгдэж байгаа.

Ер нь ойрын үед бид тэрбум долларын экспорт хийдэг боломжтой болж байна. Ялангуяа ноолуур, мах, “Цагаан алт”-тай холбоотой арьс шир, ноосны салбарын бүтээмж, экспорт тасралтгүй нэмэгдэж байгаа. Нөгөө талаас газар тариалангийн бас экспорт нь гараад эхэлсэн байгаа.

Тэгэхээр Их Хурлын баталсан хөтөлбөр үр дүнд хүрч байгаа, ажлын байрыг бий болгож байгаа.

Тэгэхээр болж өгвөл бид нарын төсвийг ахиад жоохон нэмээд өгвөл илүү их боломж бүтээмж, өгөөж гарах бололцоо бас байгаад байна.

Б.Бейсен: Ц.Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Энэ жил ч яах вэ ингээд сүүний урамшуулал эх үүсвэргүй гээд яах юм шиг байна.

Э.Энхбаяр сайд аа, ирэх жилээс судалж байгаад 2027 оноос оны төсөв дээр эртхэнээс оруулж байгаа тэр нэмэлт 4 сарын 01-нээс 5 сарын 01 хүртэлх нэг сарын хамгийн хүнд цаг, хаврын хахир цагийн урамшууллыг хэдүүлээ бодлогын хувьд оруулах нь зөв байх гэдэг саналыг хэлье.

Улаанбуудай, хүнсний ногооны урамшуулал дээр одоо балансын тооцооллоос хэмнэлт гарч ирнэ. Үгүй ээ. Хэмнэлт биш ээ. Ирэх жилийнх дээр зөрүү гарч ирнэ шүү дээ. Урамшуулал чинь үүндээ хүрээгүй шүү дээ. Ургац чинь.

Тэгэхээр үүнийг сая та өөрөө бас хэллээ шүү дээ. Зөрүү гарна. Үүнийг өөр юм руу, сүүний урамшуулал руу шилжүүлнэ гээд. Үүнийг яг дотор нь энэ салбарт ажиллаж байгаа хүмүүс чинь авсан зээлийн хүүгийн урамшуулал байгаа байхгүй юу. Хүү байгаа байхгүй юу. Төлөх. Энэ рүү шилжүүлье ээ л гэдэг санал. Энэ дээр зарчмын зөрүүтэй санал гаргаад одоо яг хэлэлцүүлгийн энэ шатанд нь явуулах боломж байгаа юм. Саналаа гаргаад. Өөр тийшээ нь биш. Яг энэ газарт... /минут дуусав/

Б.Бейсен: Хариулт Ж.Энхбаяр сайд. Дараа нь Ц.Болорчулуун сайд.

Ж.Энхбаяр: Бид маш хурдан тооцоо хийгээд танд танилцуулаадахъя. Энэ хурал явцад.

Ер нь гурил үйлдвэрлэл дээр бид 150 мянган тонн улаан буудай дутаж байгаа. Энэ хуультай холбоотойгоор үндсэндээ улаан буудайн тариалалт 110 мянган га-гаар багассан. Улсын дундажтай харьцуулаад яг 150 мянга одоо бид гаднаас импортоор авахаас аргагүй байдалд орсон.

Хүнсний ногоон дээр эх үүсвэр бас хязгаарлагдмал болохоор бид манжин үндсэндээ дотроос 100 хувь хангаж байгаа тул манжин, төмс урамшууллаас хасагдсан. Манжингаа хассан гэсэн үг. Одоо бид ургацын баланс нэмэгдэх тусам л нөгөө урамшууллуудаа хасаад эхэлж байгаа. Сангийн яам бас тийм шаарлага тавьж байгаа. Нэгэнт дэмжлэг үзүүлээд зохистой түвшинд хүрсэн тул хас гэдэг. Ингээд хасаад явж байгаа. Хүнсний ногоон дээр энэ жил 176 мянган тонн хураан авсан.

Тэгээд одоо байгаа бид нарт байгаа ногооныхоо урамшууллыг тооцоод үзэхэд ер нь их л бага зөрүү гарна. Одоо маш хурдан тооцоо хийгээд танд өгөөдөхье. Тэгээд илүү юм гарахаар бол үүнийгээ таны хэлсэн саналын дагуу томьёолоод оруулахад болохгүй зүйл байхгүй.

Б.Бейсен: Ц.Болорчулуун дарга гүйцээж хариулъя.

Ц.Болорчулуун: Ц.Туваан гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Ирэх жилийн улаан буудайн дээр 15.9 тэрбум төгрөгийн урамшуулал байгаа юм. Тэгээд яг өнөөдрийн байдлаар гурил үйлдвэрлэлд 116 мянган тонн будаа гурилын үйлдвэрүүд авчхаад байна. Тэгээд хөдөө аж ахуйн корпорацад 24 мянган тонн. Ингээд 140 мянган тонн буудай яг гурил үйлдвэрлэлд нийлүүлэгдээд байгаа юм.

Дээрээс нь 30 гаруй мянган тонн буудай одоо яг борлуулалтын шатад байна.

Тэгэхээр энэ 15 тэрбум төгрөгөөс урамшууллаас улаан буудайн дээр зөрүү гарахааргүй байгаа юм. Яг үүнийгээ өгөөд л таарахаар тооцоо гарч байгаа юм.

Хүнсний ногоо өнөөдөр 160, 170 орчим мянган тонны хураачхаад байгаа юм. Эндээсээ бид ирэх жилийн урамшуулал дээр 11 тэрбум байгаа. Үүнээс тооцоолоод үзэх юм бол манжин луувангаа хасаад тооцоход бас энэ дээрээс хэмнэлтийн зөрүү гарахгүй.

Сая сайдын хэлсэнчлэн... /минут дуусав/

Б.Бейсен: Б.Батбаатар сайд.

Б.Батбаатар: Ер нь бид Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Сангийн яаманд усны төслийн нэгжид 856.0 сая, Усны хөтөлбөр буюу энэ говийг усжуулах төсөл, хөтөлбөрт 13 тэрбум 580.0 сая төгрөгийн төсвийн саналыг бол хүргүүлсэн. Түүнээс биш бас огт ажиллахгүй буюу санал өгөхгүй байгаа зүйл байхгүй. Сангийн яаман дээр хасагдсан. Одоо ирэх жил болох гэж байгаа 297 хоногийн дараа “COP17”.

Тэгэхээр энд Ус ба газрын нэгдсэн менежментийн санаачилгын хүрээнд байгальд түшиглэсэн шийдэл бүхий дэд бүтцийн санаачилгын хүрээнд 500 сая. Зөвхөн энэ санаачилгад нь шүү. Бусдыг нь биш. 500 сая доллар буюу 1.8 их наяд төгрөгийн санхүүжилт татах боломжтой байна гэж бид ажиллаж байгаа. Тэгээд Их Хурлын гишүүд энд бас зарчмын зөрүүтэй санал оруулсан байна.

Дээрээс нь манай чухал арга хэмжээн дээр ямар... /минут дуусав/

Б.Бейсен: Б.Батбаатар сайд гүйцээж хариулъя.

Б.Батбаатар: Чухал энэ арга хэмжээн дээр ямар нэг байдлаар ийм хасалт хийхгүйгээр явж байгаад бас талархал илэрхийлье. Мэдээж энэ 856.0 саяын усны төслийн нэгж, дээрээс нь тэр 9 тэрбум гээд энэ саналууд орж ирж байна. Мөн агаарын бохирдол дээр ч гэсэн энэ саналууд дэмжигдвэл ер нь сайн л байгаа юм.

Б.Бейсен: М.Мандхай гишүүний асуулт асууя.

М.Мандхай: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Эхлээд Хөдөө аж ахуйн яамнаас асууя. Авсан одоо яг энэ Тариаланчдын холбоо, тариаланчдаас авсан мэдээллээр ургац улаан баадайн хураан авалт 59 хувьтай, төмс 76.3, хүнсний ногоо хураалт 56.4, малын тэжээл 32.3, тосны ургамал 23.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тэгэхээр энэ жил угаасаа ургац хураалт хангалттай түвшинд байж чадахгүй. Нөхцөл байдал нэлээн амаргүй байгаа. Тэгээд одоо ярьж байгаагаар бол 100 мянган тонн хүнсний буудай дутагдах ийм тооцоолол байна гэж байгаа. 150 мянга болоод нэмэгдсэн байна. Тийм ээ.

Тэгэхээр дотоодын хүнсний хэрэгцээнд нэг жилд нэг ойролцоогоор 231 мянган тонн гурил хэрэгтэй байгаагаас буудайнд шилжүүлэх юм бол 320 мянган тонн буудай хэрэглэдэг.

Тэгэхээр өнөөдрийн байдлаар хөдөө аж ахуйн корпорац дээр 188 мянган тонн дотоодын буудай нөөцтэй байна. Иймд ирэх онд гэхэд 132 мянган тонн буудай дутагдахаар нөхцөлтэй байна.

Тэгэхээр энэ дээр Хөдөө аж ахуйн яам яг одоо ямар ажил төлөвлөж ажиллаж байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаарт, зудын эрсдэлийн улмаас хорогдох магадлалтай малын зудын нөлөөлөл хонин толгойд шилжүүлэхээр дунджаар 5.2 сая хонь хорогдох эрсдэлтэй гэсэн тооцоолол гарсан байна. Энэ эрсдэлийг бууруулах үүднээс тэжээлийн нөөц, цаашид бэлдэх боломжтой хэмжээ, хангамжид тулгуурлаж байгаа хээлтэгч мал, хээлтүүлэгч малтайгаа авч үзэхэд энэ эр сувай малыг мах бэлтгэлд оруулах гарц байгаа юм болов уу? Энэ дээр ер нь Хөдөө аж ахуйн яам ямар төлөвлөгөөтэй ажиллаж байгаа вэ гэж хэлмээр байна. Яг одоогийн нөхцөл байдал дээр мэдээ харж байхад малчид зах дээр үхрийн мах их орж ирж зарж байгаа юм шиг боловч удахгүй дотоодын хэрэгцээ угаасаа хангагдаад ирнэ.

Тэгэхээр нэлээн бухимдал үүсэх ийм нөхцөл байдалтай байгаа.

Тэгэхээр энэ дээр яам энэ эрсдэлүүдэд одоо яг ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ? Тэгээд дутагдаж байгаа хүнсний буудайн нөөцийг бүрдүүлэхэд урамшуулал харах юм бол үндсэндээ 20 орчим тэрбум төгрөг л байхаар харагдаж байна. Энэ ингээд он дуусахад дуусах байлгүй.

Тэгэхээр энэ дээр яг ямар арга хэмжээ авч ажиллая гэсэн төлөвлөгөөтэй байгаа вэ гэдэг нэг төлөвлөгөөг нь сонсьё.

Хоёрдугаарт, сангийн орлогын өсөлт нэмэгдсэн байгаа. Ажил эрхлэлтийн тоо өссөн тоо нэмэгдсэн үү? Эсвэл энэ дундаж цалин өссөн үү гэдгийг мэдмээр байна. Энэ жин нь яг аль талдаа нэмэгдэж байгаа вэ гэдгийг асуумаар байгаа юм.

Яг бодит төсөөллөөр харах юм бол биеллээ орохооргүй харагдаж байгаа. Төсвөөс олох татаас бол... /минут дуусав/

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд.

Ж.Энхбаяр: Бид өнгөрсөн зудын сургамжаас дүгнэлт хийж ажиллаж байгаа. Тэр үед 9.2 сая толгой мал бид алдсан. Тэрбум долларын хохирол авч учирч байсан.

Энэ дээр дүгнэлт хийгээд бид малын махны экспорт дээр идэвхжүүлэлт арга хэмжээг авсан. Өнөөгийн байдлаар дэлхийн 17 оронд манай мал мах экспорт явж байна. Монгол Улсын махны үйлдвэрүүд бүгд тасралтгүй ажиллаж байна. Одоогийн байдлаар бид 160-аад сая долларын мах экспортод гаргаад байна. Оны сүүл гэхэд 300 сая доллар давахаар ийм төлөв байна. Нийт

хийгдсэн гэрээ 142 мянган тонн буюу хонин толгойд шилжүүлснээр 7 сая хонь экспортлох төлөвтэй байна.

Ялангуяа зудын эрсдэл өндөр баруун аймгууд дээр мал бэлтгэлийг маш эрчимтэй зохион байгуулсан. Үндсэндээ малчид борлуулах малаа үйлдвэрүүдэд нийлүүлээд бараг дууссан байна.

Хадлан тэжээлтэй холбоотойгоор бэлтгэл ажлыг зүүн бүсүүдэд зохион байгуулж, газар олголт, хадлангийн тасгуудыг гаргах ажлуудыг салонуудыг гаргах ажлыг зохион байгуулсан. Ингээд өвс тэжээл баруун тийшээ эрчимтэй ачигдаж байна. Зөрөөд мал наашаа төвийн бүс рүүгээ татагдаж байгаа буюу бид эрсдэлийг аль болох багасгах чиглэлийн ажлууд амжилттай хийгдсэн. Тэгээд гол зүйл бол мал махны экспорт. Энэ нь бол малчдад бас нэлээн дэмжлэг авч байна. Яагаад гэвэл экспортод гарснаар махны үнэ нэлээн боломжийн тогтож байна. Малчдын орлого буюу үүнийгээ дагаад өвс тэжээлээ бэлтгэх эдийн засгийн нөхцөл байдал бүрэлдэж байна.

Ургацтай холбоотой дутагдлыг бид мэдээж импортоор нөхөхөөс аргагүй.

Тэгэхээр хууль эрх зүйн орчноор их бодолтой оролдох хэрэгтэй. Энд бас бодлогын алдаа гарсан. Улаан буудайн тариалалт 100 мянгаар 2 жил дараалаад уналаа. Үүний яг ургацынхаа дундажтай тааруулаад 150-аад мянган тонны баланс бол ур улаан буудайн хэрэгцээ дутна. Үүнийг нөхөхийн тулд бид эхний ээлжинд дотооддоо байгаа бүх улаан буудайн худалдан авалт үндсэндээ хийгдээд дуусаж байна. Таны мэдээ нэлээн өмнөх мэдээ байх шиг байна? Одоо аж ахуйн нэгжүүд дээр 2 мянга гаруй тонн улаан буудай үлдсэн. Бусад нь бүгд үйлдвэрийн хашаанд буугдаад агуулахад хадгалагдсан.

23-ны байдлаар нийт

- 216 мянган га-д улаан буудай таригдсанаас 239 мянган тонн үр тариа,
- 9.9 мянган га-гаас 101.4 мянган тонн төмс,
- 13.3 мянган га-гаас 176.4 мянган тонн,
- бусад хүнсний ногоо, малын тэжээл 32.6 мянган га-гаас 78.5 мянган тонн,
- тосны ургамал 47.2 мянган га-гаас 22.2 мянган тонн ургац тус тус хураан авсан.

Төмс, улаан буудай, ургац хураалт үндсэндээ дууслаа.

Үтрэмийн ажлууд үндсэндээ дууссан.

Нийт 31 мянган цэрэг, албан хаагчид, оюутнууд хөдөө аж ахуйн газар ажиллалаа. Ямар нэгэн хэл ам байхгүй, аваар осол байхгүй ургацыг бүрэн хурааж холбогдох үйлдвэрүүд улаан буудайн нөгөө Тариалан эрхлэлт дэмжих сан буюу одоо манай Хөдөө аж ахуйн корпорацийн агуулахуудад бүрэн тээвэрлэгдэж очсон.

Ингээд тариалангийн бүс нутагт 10 сарын 13-наас 16-ны өдрүүдэд орсон цасны нөлөөгөөр тосны ургамал болон тэжээлийн таримлын хураалт 3, 4 хоног саатаж байна.

Энэ долоо хоног таатай байна. Энэ хугацаанд багтаад үндсэндээ газар тариалангийн жилийн төлөвлөгөөт ажил энэ 10 сардаа багтаж 11 сарын 01-н гэхэд бүрэн дуусна. Ямар нэгэн эрсдэл буюу хүндрэл учрахгүй.

Тэгэхээр дутаг... /минут дуусав/

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Үйлдвэрлэлд дутагдах улаан буудайг бид эхний ээлжид энэ жилийн ган буюу бас халалттай холбоотойгоор нөгөө талаас улаан буудайн чанарт чанарын ахиц их гарсан. Илүү цавуулаг их сайжирсан.

Дотоодынхоо улаан буудайгаар бид гурил үйлдвэрлэл рүүгээ шахаад дутаж байгаагаа бид гурилын үйлдвэрүүдээ квот олгох замаар импортоор хангана.

Мөн шувууны үйлдвэрлэл нэлээн их томорсон. Монгол Улс үндсэндээ өндгөө 100 хувь дотоодоо хангаж эхэлж байна. Жилдээ бараг 60 мянган тонн улаан буудайг тэжээлд хэрэглэж эхэлж байна.

Мөн гахайны аж ахуй байна. Мөн сүү, бусад эрчимжсэн мал аж ахуй дээр үр тарианы хэрэглээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор “Атрын-4” дүгээр аяныг эрчимжүүлэх, нөгөө 200 мянган га талбайн олголт, тэжээлийн таримлыг нэмэгдүүлэх бодлогыг орон нутгуудтай хамтраад ажлуудаа явуулаад эхэлж байна. Тэгээд ирэх жилээс нэлээн тариалалт нэмэгдэж дутагдлыг бид дотроосоо хангах бололцоо бүрдэнэ.

Гурилын үйлдвэрүүдэд ийм... /минут дуусав/

Б.Бейсен: М.Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Яах вэ, Та эрсдэлүүдээ уг нь бодитой хэлбэл бид энд төсөв дээр чинь яаж дэмжиж ажиллах вэ гэдэг талаар нээлттэй яримаар байгаа юм.

Яг миний авч байгаа мэдээллээр тариаланчдын хэлж байгаагаар үндсэндээ гангийн улмаас дараа оны тариалалтад шаардлагатай улаан буудай, төмсний үрийн нөөц бүрдүүлж чадахааргүй байгаа.

Одоо үр тариа, төмс хүнсний ногоо хураалтад сая ажиллах хүч хомс. Төдийлөн авсан цэрэг оюутнуудын ажиллах хугацаа богино байсан учраас хүндрэлтэй байсан гэдэг талаар ярьж байсан. Тэгээд та бол болно. Бид ямар ч асуудалгүй ээ гэсэн хариулт өгөөд байх шиг байна л даа. Яах вэ.

Тэгээд хүнсний хангамжтай би түрүүн асуулт асуусан. Өнөөдрийн байдлаар 188 мянган тонн дотоодын буудайн нөөцтэй байгаа. Ирэх онд 132 мянган тонн буудай дутагдахаар юм байна. Гурилын... /минут дуусав/

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Манай тариаланчид, аж ахуйн нэгжүүд уламжлалаараа өөрсдийнхөө үрийг хадгалж үлддэг. Гангийн нөхцөл байдалтай холбоотойгоор ургац алдсан газруудад үрийн асуудал хүндэрнэ. Ингэж тооцоод бид сая энэ жилийн ургацаасаа үр үржүүлгийн аж ахуйн нэгжүүдээсээ сонгон шалгаруулалт, чанар байдлын үнэлгээг нь хийгээд 10 мянган тонн үрийн нөөцийг бүрдүүлсэн байгаа.

Тэгэхээр энэ 10 мянган тонн үртэйгээ бид ирэх жилийн тариалалтыг амжилттай явуулах бүрэн бололцоотой. Энэ жилийн нэг онцлог бол намрын чийг их өндөр буюу уриншийн ажил нэлээн сайн хийгдлээ. Ирэх жил бид нэгэнт хууль эрх зүйн орчин засагдсан тул ирэх жил Монгол Улс улаан буудайн тариалалт бол эрс идэвхжих ерөнхий төлөв байдал үүсэж байна.

Төмс, хүнсний ногоон дээр үрийн шинэчлэл зайлшгүй байгаа. Ялангуяа төмс дээр бид тодорхой хэмжээний эх үүсвэр тавиад хүнсний болон үрийн будаан нөөц бүрдүүлэх чиглэлээр бид жоохон төсөв... /минут дуусав/

Б.Бейсен: М.Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Тэгэхээр түрүүн хэлж байсан 132 мянган тонн буудай ирэх онд ерөнхийдөө дутагдахаар тооцоололтой байна. Би хөдөө аж ахуйн корпорацаас 3 хоногийн өмнө утасдаж мэдээлэл авсан.

Тэгээд гурилын үйлдвэртэй үнэ өсөхгүй гэдэг тогтвортой байдлын гэрээ ер нь хийгээд квот өгөх тал дээр яам ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ гэдгийг дахиад тодруулж асууя.

Хоёрт нь, тэр сангийн орлогын өсөлтийг хэлээд өгөөч. 6.1 их наяд байхаар тооцсон байсан. Тэгээд энэ ажил эрхлэлтийн тоо нэмэгдсэн үү, эсвэл дундаж цалин өссөн үү гэдэг дээр нэг асуугаад тэгээд хариулт тодруулъя.

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Гурилын үйлдвэрүүддээ квот олгож байгаа. Нэг талаас. Нөгөө талаас гурил үйлдвэрлэх шаардлагатай улаан буудайг бүрдүүлэхэд зориулсан хөнгөлөлттэй зээлийг бид арилжааны 10 банкуудтай яриад тэр бололцоог нь бас нээж өгч байгаа. Энэ хэмжээнд л гурилын үйлдвэртэй бид харьцаж байгаа.

Гурилын үйлдвэрүүд маань ялангуяа тээврийн зардалтай холбоотойгоор үнэ өндөр гараад байгаа баруун 5 аймагт бөөнийхөө төвийг нээсэн. Тэнд үйлдвэрийн үнээр баруун 5 аймагт дотоодын гурилын үйлдвэрүүд бөөний борлуулалтыг хийж эхэлсэн байгаа.

Тэгэхээр гурилтай холбоотойгоор тийм үнийн өсөлт яамны зохицуулалтын зүгээс гарахгүй.

Тэгэхээр энэ дээрээ хаана хаанаа бас хяналт тавиад ажиллахад гурилын нийлүүлэлтэд санаа зовох юм байхгүй. Энэ жилийн цагаан сараар бид монгол гурилаа улаан буудайгаар хийсэн гурилаараа хангалттай хийнэ. Хаврын жоохон дутагдлыг бид импортын квот, гурилын үйлдвэрүүд... /минут дуусав/

Б.Бейсен: Сангийн яамнаасаас Ж.Ганбат дарга. М.Санжаадорж 8 номер.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Сангийн гээд нийгмийн даатгалын сангийн орлогыг ярьж байна гэж ойлголоо. Тийм ээ. Нийгмийн даатгалын сангийн орлого ингэж байгаа. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналаар тоо нь бараг тэр чигээрээ орж ирсэн байгаа.

Ер нь манайх татвар дээр хувь хүний орлогын албан татварын мэдээлэл байдаг учраас тэр мэдээллээрээ давхар шалгадаг юм.

Тэгэхээр улсын хэмжээний нийт цалингийн санг бид тооцож гаргаад, эндээсээ ирэх жил жил болгон 15 орчим хувиар энэ нэмэгдээд явдаг юм. Тэр тооцоогоо нэмж оруулаад тэндээсээ шимтгэлийн хэмжээ бол хэд байх вэ гэдгээ тооцож байгаа юм.

Тэгэхээр татвар нөгөө шимтгэлийн дараах үлдэж байгаа хэсгээс тооцдог. Шимтгэл эхлээд авдаг учраас арай өөр тоогоор тэднийх зөрүү нь гарч ирдэг. Манайх нийгмийн даатгалын орлогууд дээр нэг орлого нэмсэн нь хүүгийн орлого байгаа. Арилжааны банканд хадгалах хүүгийн орлого.

Б.Бейсен: М.Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Яах вэ, би ингэж асуух гээд байгаа юм. Одоо яг бодитой нэмэгдэл байж чадахааргүй харагдаад байгаа байхгүй юу. Одоо энэ чинь төсвийн орлого угаасаа буурах эрсдэлтэй байна шүү дээ.

Тэгэхээр улсын төсвийн олгох татаас чинь өөрөө 1.4 гээд их наяд байгаа.

Тэгэхээр энэ төсвөөс олгох татаас чинь одоо яг яаж олгогдох юм бэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тэтгэврийн нэмэгдэл байтугай багш, эмч нарын цалингийн асуудлыг нэмэх талаар ярьж байгаа.

Тэгэхээр яг энэ бодитой нэмэгдэж чадах уу? Инфляцтай уялдуулаад тэтгэврийг нэмэх асуудлыг төсөв дээрээ төлөвлөөд тавьсан байж байдаг.

Улсын төсвөөс олгох татаас чинь өөрөө яг бодитой олгогдох уу л гэсэн л асуулт асуух гээд байгаа юм л даа.

Б.Бейсен: 8 номер. М.Санжаадорж хариулъя.

М.Санжаадорж: М.Санжаадорж. Сангийн яам. Гишүүний асуултад нэмж хариулъя.

Тэгэхээр 1.4 их наядын татаас ирэх жил өгөхөөр байгаа. Гэхдээ хуулиараа хариуцна гэсэн зардлууд байгаад байдаг. Жишээ нь, цэргийн албан хаагч тэтгэвэрт шимтгэл төлдөггүй. Тэтгэвэрт гарсных нь дараа тэтгэврийг нь улсын төсвөөс өгдөг. Энэ зардлуудаа оруулаад тооцохоор цаанаа нь 300 орчим тэрбум төгрөг төсвөөс цэвэр алдагдалд нь зориулж татаас өгч байгаа.

Одоо хэрвээ тэтгэвэр нэмнэ гэх юм бол шимтгэлийн орлого маань хязгаартай учраас орлогыг нь нэмж бид жишээ нь тэтгэвэр нэмж болохгүй.

Тийм учраас дахиад энэ татаасаа нэмэхээс л өөр аргагүй болно. Хэрвээ 8 пунктээр гэх юм бол 126 тэрбум төгрөг татаасаа нэмнэ. Түүнээс дээшээ гэх юм бол 10 пунктээр нэмэх юм бол өшөө дахиад 250 орчим тэрбум төгрөгийн татаас нэмээд л явахаас өөр аргагүй болно. Цалингийн хувьд хэрвээ цалингаа нэмэх

юм бол бас инфляцтай нь яаж нөлөөлөх вэ гэдэг тооцоод давхар хийгдэх ёстой. Тэр нь төсвийн хүрээний мэдэгдэл дээр бас орох ёстой. Тийм.

Б.Бейсен: С.Одонтуяа сайд асуулт асууя.

С.Одонтуяа: Үг хэлье.

Тэгэхээр ард түмэн Их Хурлын хэрүүлээс залхаж байгаа байх.

Тэгэхээр ганц гэгээтэй, ганц мега төсөл хийх юмсан. Говийг усжуулах төсөл байгаа. Тэгэхээр үүнийг бид заавал хийх хэрэгтэй гэж бодож байна. Одоо говийн баялгийг бид хангалттай л сорж байна шүү дээ. Тэгэхэд ганц усны төслийг нь явуулж чадахгүй ийм арчаагүй байж болохгүй.

Одоогоос бүр 40-өөс 50 жилийн өмнө Эрдэнэт хот руу Булган аймгаас хоолой татсан. 67 километр 3 хоолой татаж өнөөдөр Эрдэнэт Монгол Улсыг тэжээж байна. Тэр хоолой татаагүй бол Эрдэнэт усгүй. Өнөөдөр Булган аймаг тэр усныхаа орлогоор нэлээд хэдэн тэрбумыг олж байна.

Тэгэхээр яагаад 40, 50 жилийн өмнө хийж болоод байсан юм одоо нэг хэдхэн төгрөгийг нь шийдээд говийн усыг нь шийдье л дээ. Төсөв нь тэлээд л байдаг. Ганц ч мега төсөлгүй Их Хуралд сууж баймааргүй байна.

Тэгээд би Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас тайланг сонсоход Ж.Энхбаяр сайдад бараг экспортын орлого нь тэрбум доллар луу дөхөж байгаа байхгүй юу.

Тэгэхээр эднийх нэлээд олон тэрбумаар татаасуудыг аваад энэ салбараа ингээд бодитой дэмжээд байхаар энэ чинь яваад байна. Гэтэл байгаль орчны салбарт юу ч байхгүй. 345 сая төгрөг усанд өгч байна гэдэг чинь арай доромжилж байгаа байхгүй юу. Энэ чинь уснаас маш их мөнгө олж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ усны төслийг заавал явуулъя гэж би саналтай байгаа юм. Тэгээд энэ “Онги-Цагаанбургастай” төсөл чинь өөрөө экологийн төсөл байгаа юм. Эхлээд бид экологийн төслөө хийгээд, Улааннуураа сэргээгээд тэгээд говийгоо усжуулах нь шат дараалсан ажил.

Намайг сайд авахад л ерөөсөө хүн бүхэн нөгөө “Хэрлэн-Тооно”, “Орхон-Онги” чинь юу болж байна л гээд л бүгд асуудаг.

Тэгэхээр ядаж бид энэ ТЭЗҮ-г нь хийгээд, энэ юмнуудыг нь явуулмаар байна шүү дээ.

Тэгэхээр ядаж бид нар олон хэрүүл биш, өчнөөн их наядаар төсөв чинь тэлээд байдаг ганцхан говийн хэдхэн төгрөгийг нь шийдээд явуулмаар байна. Би гишүүддээ үүнийг уриалж байна шүү. Тэгэхгүй бол бас арай л дэндүү байна гэж хэлэх гээд байна. Баярлалаа.

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний салбаруудын 2026 оны төсвийн асуудал яригдаж байна л даа.

Хөдөө аж ахуйн салбар яах аргагүй улс орны өөрийнх нь эдийн засгийн үндсэн салбар нь. Ард иргэдийнх нь амь амьжиргааных нь асуудал байгаа юм. Тэгээд үүнийгээ заримдаа бид хэд ярихаараа нэлээн саваад, жоохон ад үзэм маягтай юм ярьцаагаад болж өгөхгүй байгаад байгаа юм. Ний нуугүй үнэнийг хэлэхэд.

Хүнс хэрэглэдэггүй хүн байдаггүй, хувцас хунар өмсдөггүй хүн байдаггүй. Түүнийгээ дотоодоосоо бий болгоё оо л гэвэл энэ салбарт төрийн бодлого дэмжлэг зайлшгүй шаардлагатай.

Тэгээд энэ салбар өөрөө байгаль цаг уурынхаа хараат салбар байгаад байдаг. Бидний эс хүссэнээс үл хамаараад нөхцөл байдал нэлээн тийм төвөгтэй нөхцөлүүдийг бий болгоод байна.

Тийм учраас аюулгүйн буюу технологийн нөөц бүрдүүлэлтийнхээ асуудлуудыг бид онцгой анхаарах ёстой юм. Дан дамаа гол таримлууд дээр бид хийж явах ёстой. Хүнсний хангамж, аюулгүй байдал тэр үндэсний хөдөлгөөний хүрээнд, тэр том төлөвлөгөө батлагдаад стратегийн нөөцөө бид ерөнхийдөө дөхүүлсэн байх. Би одоо нэг тийм хэмжээний юм бүрдүүлэх бололцоо бий болсон гэж ойлгоод байдаг.

Жинхэнэ аминд ордог өнөө ганц технологийн нөөц бүрдүүлэлтээ шийдэж чадахгүй яваад байгаа. Үүнийг шийдэх тал дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам ирэх оны төсөв дээр ер нь ямархуу зохицуулалтын юмнууд байна вэ? Энэ дээр нэг тодорхой хариу авмаар байна гэж.

Хоёрдугаарт, төмсний салбар дээр бид бодох ёстой. Үрийн материал буюу булцуу хөгжүүлэлтийнхээ асуудлыг дотооддоо бид хийж чаддаг л байх ёстой. Үүнийгээ тэр Ургамал, газар тариалангийн хүрээлэн гэдэг юм уу, үрийн аж ахуйнуудаа түшиглэж зохицуулах ямар бодлого, шийдлүүд байна вэ? Төсвөөр баталгаажиж байгаа юм байна уу гэж.

Шууд үрийн дутагдлыг ирэх жил яалт ч байхгүй хөдөө аж ахуйн салбарт олгох зээлийн дэмжлэгээр нь дамжуулж л шийдэхээс арга байхгүй. Түүгээрээ шийдэх бололцоо бий. Гэхдээ бид хэдийн өнөө Гаалийн албан татварыг чөлөөлсөн хуулиа хүчингүй болгосон маань цаг хугацаа хоцорч гарсантай холбогдоод 2025 оны тариалалтад нөлөө үзүүлж чадаагүй. 2026 оны тариалалтад нэлээн том дэмжлэг болох юм байна лээ. Ихэнх аж ахуйнууд уринш боловсруулалтыг маш сайн хийсэн. Үндсэндээ ирэх жил тариалах талбайгаа бэлдсэн гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр үүнийг хийхийн тулд... /минут дуусав/

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүнд 1 минут.

Ж.Батжаргал: Үүнийг хийхийн тулд хэдүүлээ энэ жилийнх нь ган гачгийг харгалзаж зээлийн ухралт хийнэ гэвэл ирэх жил наад улсууд чинь зээл авах гэхээр баталгаа хөрөнгийнх нь асуудал яригдана.

Тэгээд ямар бодлоготойгоор энэ зээлийг шийдэж байж хагас үйлдвэрлэл буюу бэлдсэн талбайдаа тариалалт буюу үйлдвэрлэл хийж байж ургацаа авах юм бэ гэдэг асуудал бидний хамгийн том асуудал болоод байгаа юм. Энэ дээр тэр Зээлийн батлан даалтын сан дээр үүнийг шийдэх хэмжээний чөлөөт эх үүсвэр байна уу, үгүй юу? Энэ дээр би сайдыг нэг тодорхой хариулт өгөөч гэж.

Ороод ирсэн санал хураалгах гээд байгаа асуудлуудыг харлаа. Яг энэ төр хөдөө аж ахуйн салбараа дэмжиж юм хийж байгаа улсуудаа дэмжье гэвэл урамшууллын л асуудал байгаа. Үүнийг нь жаал хасахаар юм орж ирээд байна. Энэ дээрээ сайд их тодорхой тайлбар өгч гишүүдийг зөв мэдээлэлжүүлж байж санал хураалгахгүй бол энэ чинь хэдүүлээ нэг талдаа дэм... /минут дуусав/

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд хариулья.

Ж.Энхбаяр: Салбарын төсөв байнга хасагдаж байгаа. Төсвийн хүрээ өргөн барьснаасаа ахиад л хасагдаж байгаа. Сая багш, эмч нарын цалинтай холбоотойгоор мөн дахин хасахаас аргагүй байдал үүсэж байгаа.

Тэгэхээр бид нарын боломж их хязгаарлагдмал. Тэгээд байгаа үрийн нөөц бүрдүүлэх эх үүсвэр маань тун бага байгаа. Гэхдээ бага гэлтгүй бид бас үүнийгээ тэгээд л сайн зохион байгуулаад ашиглаж чадвал болох байх л гэсэн тийм бодолтой. Ялангуяа төмс дээр ямар нэгэн эх үүсвэрүүд ерөөсөө дутагдалтай байхгүй тэг байгаа. Нөгөө талаас төмс үржүүлгийн хүрээлэнгүүдийн бодлого үйл ажиллагаа яамнаасаа их тусдаа яваад байгаа нэг зовлон байгаа. Би байнга л ярьж байгаа юм. Байнгын хороонд. Хөдөө аж ахуйн яамны дэргэд байх ёстой энэ хөдөө аж ахуйн салбарын энэ хүрээлэнгүүдийг энэ бодлогын

хувьд наашаа нэгтгэж өгөөч ээ. Энэ чинь үйл ажиллагааг нь салгаад хаяж байгаа юм. Хүний нөөц бэлддэг сургуулиуд нь тусдаа. Яамандаа зөвлөх ёстой мэргэжлийн тэр хүрээлэнгүүд нь тусдаа болгоод хаясан. Тэгээд салбар хооронд төсөв хөрөнгө мөнгө шилжих ямар ч бололцоо байхгүй. Санхүүжих ямар нэгэн ажил арга хэмжээ хуулиар хязгаарлагдсан хориотой.

Тэгэхээр үүнийг нэг ахиж эргэж хараач. Үүнийг шийдэхгүйгээр одоо тэр шинжлэх ухааны хөдөө аж ахуйн салбарынхаа ололт амжилтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх юм бол үнэхээр их олон саадыг тулаад байгаа.

Тэгэхээр ингээд хөдөө аж ахуйн салбар гэдэг бол маш ийм цогц. Газар тариалан, мал аж ахуй байгаль орчин, усжуулалт, ингээд үйлдвэрлэл гээд ингээд ажлын байр, нийгмийн баялаг, нийгмийн тогтвортой байдал гээд цогц байгаа юм.

Тэгэхээр манай Их Хурлын онцгой их давуу тал бол энэ 4 багц хөтөлбөрийг баталсан байхгүй юу. “Атрын-4”, тариа ногоо, малчин, хоршоо, үйлдвэрлэл буюу “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” гэсэн цогцоор нь баталсан болохоор цогц систем чинь дөрвүүлээ ажиллаад эхлэхээр эдийн засгийн өсөлт, олон мянган ажлын байр бий болгоод байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүн үзүүлэх нөлөөлөл нэмэгдээд байгаа ч энэ.

Тэгэхээр энэ бодлогоо бүгдээрээ ахиад 2 жил аваад гарахад энэ бол энэ Их Хурлын хийсэн ажил. Энэ Их Хурлын бүх гишүүд очиж байж орон нутагт бид ийм зүйл хийлээ бүтээлээ гэж л бүгд ярих нийтлэг салбар шүү дээ. Тийм.

Тэгэхээр энэ орж ирсэн хасах. Үндсэндээ манай үйл ажиллагааг бүрэн зогсоох гэсэн хасах саналууд их өндөр байна.

Тэгэхээр үүнийг л яагаад ч дэмжиж болмооргүй л харагдаад байх юм. Энэ дээр гишүүд маань анхаарна уу гэж хэлье дээ.

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тэгээд салбарын яам сайд их сайн бодно биз дээ. Энэ яваад байгаа төсөл, арга хэмжээнүүд тодорхой бүс дээр төвлөрчхөөд байна гэж юм яриад байгаа.

Тийм учраас Улсын Их Хурлаас батлаад өгч байгаа төсвийг нь сул хөгжилтэй байгаа бүс нутгууд дээрээ тодорхой чадамж бий болгох асуудал руугаа төлөвлөлтөө та нарийсгаж хийнэ биз. Би ингэж ойлгож байна.

Би Их Хурлын гишүүдийг хөдөө аж ахуйн салбарынхаа одоогоор дутуу төлөвлөгдөөд байгаа юмнаас нь дахиад хасна гэдэг энэ байр сууриа нэг

бодолцож санал юмнуудаа өгөөрэй гэдгийг хэлмээр байна. Хэдүүлээ худлаа ярьж болохгүй байхгүй юу. Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлье, дагуулаад боловсруулах салбарыг нь хөгжүүлье. Тэгээд дотоодынхоо хэрэгцээг хангая. Ажлын байраа бий болгоё, экспортын үзэл баримтлал бий болгоё гэж ярих. Нөгөө талдаа үүнийгээ дэмжсэн жаал юмаа хасна гэж ярьж байгаа нь... /минут дуусав/

Б.Бейсен: Үг хэллээ. Сая гишүүдийн ихэнхээс нь гарч байна. Говийн аймгуудад хөрөнгө оруулалтыг хянан бүрдүүлж төсөл бүрдүүлж байгаа. Энэ ус татах асуудал дээр нэлээн бодууштай асуудал байгаа. Яагаад гэвэл та бүгд мэдэж байна. Хөрш зэргэлдээ Хятад, Казахстан, Узбек улсууд ус татаад тариалангаа хөгжүүлж байна.

Говь руугаа ус татах тэр юуны усны газрын Ус ашиглалт, технологийн хэлтсийн дарга геодези, зураг зүйн юугаа гаргаад л ямар газар нь юу татах юм? Нуур цөөрөм хаана үүсэх юм? Энэ талын асуудал дээр бас зураг төсвийг нь гаргаад шийдэхгүй бол дэлхийн конвенц гээд байдаг бусад улс орнууд ашиглаж байдаг. Манайх л тийм асуудал байж байна.

Тийм учраас говийн ус татах асуудал дээр анхаарч ажиллаарай гэж хэлье.

Дараа нь нэг хэдэн асуулт байна. С.Магнайсүрэн Ерөнхий аудиторгоос асууя. “Шинэ хоршоо” хөдөлгөөнд олгосон зээл байна шүү дээ. Бараг 800 хэдэн тэрбум өгчхөв үү, их наяд шахуу зээл өгсөн. Үүний эргэн төлөлт дээр нь аудит хийж үзсэн үү? Ер нь.

Зарим гишүүд энэ чинь найдваргүй зээл боллоо гээд ярьж байна. Хэчнээн төгрөг нь эргэн төлөлттэй байна? Энэ талаар асууя?

Ж.Энхбаяр сайдаас баруун аймгуудын тэр тэжээлийн асуудал. Гурилын. Түрүүн манай гишүүд Засгийн газрын хуралдаанаар орлоо. Гурил, тэжээл чөлөөт орохоор боллоо гээд л юм ярьсан. Засгийн газрын хуралдаан дээрээ шийдэгдсэн юм уу, шийдэгдээгүй юм уу? Цаашдаа яах юм?

Одоо тэжээлийг бол ерөөсөө гурил авбал өгнө, тэгэхгүй бол өгөхгүй, тэжээл өгөхгүй байна гэдэг асуудал гарч байна.

Дараа нь малын түүхий эд боловсруулах үйлдвэрийг чинь зүүн аймагт Замын-Үүд, Эмээлт, баруун аймагт Ховд, Дарханд гээд. Үүний явц хэр байна? Энэ үйлдвэрүүд байгуулагдах янз байна уу? Урьд нь бас төсөв хуваарилж байсан. Энэ талаар мэдээлэл авъя.

Б.Бейсен: Аудитын газрын дарга байна уу? Орлогч нь хэн гэж байна?
3.Цэдэнжав. 9 номер хариулъя.

Б.Батбямба: Гишүүний асуултад хариулъя. Шадар сайдын ахлах зөвлөх Б.Батбямба байна.

Өнгөрсөн хугацаанд 2024, 2025 онд нийтдээ 854.8 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байгаа. Энэ зээлийн эргэн төлөлт 98-аас дээш хувьтай байна. Одоогийн байдлаар нийтдээ 68.5 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуйн үйлдвэр, технологийн парк 3 газар хэрэгжиж байна.

Нэгдүгээрт, Ховд. Ховд үндсэндээ энэ жил хамгийн сүүлийн төсвүүд нь тавигдаад дуусаж байна. Ингэснээр Ховдын үйлдвэр, технологийн паркт хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт хийх таатай нөхцөл бүрдэнэ. Газар үнэгүй. Тог цахилгаан, дулаан, бусад дэд бүтцээр бүрэн хангагдсан орчин бүрдэнэ. Энд хувийн хэвшил хөрөнгө оруулалтаа хийгээд явах бололцоотой.

Яг ийм маягийн загвар Дархан хотод байгаа төсвийнхөө хэмжээнд бас хийгдэж байна. Энэ жил үйлдвэр, технологийн парк руу тавигдах замын ажил хийгдээд дуусаж байна.

Ирэх жил бас бага хэмжээний 8 тэрбум төгрөгийн орчим байгаа. Үүгээр эрчим хүчнийхээ шугамууд татна. Ингээд тавигдсан хэмжээнд л бид ажлаа зохион байгуулж байна.

Улаанбаатар хотод бол Улаанбаатар хотод байгаа арьс ширний 24 үйлдвэр байгаа юм. Яг хотын төв суурьшлын бүсэд орсон. Үүнийг гаргахын үүднээс Эмээлт үйлдвэр, технологийн паркийг хийх ажил явагдаж байна. 24 мегаваттын эрчим хүч, цахилгаан станц, цэвэрлэх байгууламж, дэд бүтцийн ажил улс нийслэлийн төсөв дээр нийт 235.0 тэрбум төгрөгийн өртөгтэйгөөр нийслэлийн төсөв дээр суугаад ажил үргэлжилж байна.

Ингээд ийм 3 газар ингээд боловсруулах үйлдвэрүүд төвлөрүүлэх бодлого хэрэгжиж байгаа.

Нөгөө талаас баруун бүсийн гурил тэжээлийн тогтвортой байдалтай холбоотой ямар асуудал Засгийн газар оров оо гэж. Засгийн газарт бүх нөөц хувилбарыг танилцуулсан. Засгийн газар дэмжсэн. Хуулийн хувьд заавал Улсын

Их Хурлаас эрх авахгүй бол Засгийн газар татвартай холбоотой асуудлыг шийдэх нь боломжгүй гэдэг дүгнэлтийг Хууль зүйн яам гаргасан.

Ингээд бид Улсын Их Хуралд өргөн барихаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл болгосон хэлбэрээр одоо сая Засгийн газраар орж хэлэлцүүлээд Их Хуралд одоо орж ирнэ. Тэр үед гишүүд дэмжээд яв юм бол энэ зохицуулалтууд хийгд байх.

Бид наана зохицуулж юу хийсэн бэ гэвэл гурилын үйлдвэрүүдийн бөөний үнийг бид баруун 5 аймаг дээр тавьсан. Бөөний төвүүдийг нээж ажиллуулж байгаа.

Нөгөө талаас 104 мянган тонн тэжээл баруун бүс нутгаар импортоор авах импортын мэдэгдлүүдээ аж ахуйн нэгжүүд аваад цаад гадаад нөгөө татаж авах ажиллагаанууд нь хийгдэж байна.

Зүүн бүсээс өвс тэжээл бас мөн баруун тийшээ идэвхтэй явж байна. Нөгөө талаас баруун бүсэд мах бэлтгэлийг төвлөрүүлсэн нэлээн их хэмжээний гол мах баруун бүс нутгаас гарсан. Үндсэндээ аль болох эрсдэлийг хаах ийм чиглэлийн ажлуудыг л зохион байгуулж байна гэж хэлье.

Нэмэлт юм байвал манай 8 номер хариулаарай.

Б.Бейсен: Байгаль орчны яамнаас бас асууя.

Хөдөө аж ахуйн яамны сайд байгаа дээр. Энэ баруун аймгуудын хил орчим бүсийн отрын асуудал байна. Хүнд. Яг хил орчим тусгай хамгаалалттай газар. Одоо яг оторт гарахгүй бол болохоо байлаа. Зөвшөөрөл олгогдохгүй байна гэж тэгж байна. Хил хамгаалах ерөнхий газартай хамтраад хэчнээн аймгаас зөвшөөрөл ирсэн юм бол. Тэрийг шийдсэн асуудал байна уу?

Б.Батбаатар сайд.

Б.Батбаатар: 6 номер дээрээс хариулъя. Төрийн нарийн бичгийн дарга.

Б.Бейсен: 6 номер.

Ш.Батбаяр: Энэ жилийн өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотойгоор тусгай хамгаалалттай газарт 230 гаруй мянган малыг байршуулахаар шийдвэр гарсан байгаа. 23 хамгаалалтын захиргаанд байгаа. Аймаг аймгаар хэлэх үү?

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайдад нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Тусгай хамгаалалттай 23 захиргааны хариуцлагын бүсэд саяын хэлдгээр нь 230-аад мянган мал орж өвөлжихөөр зохицуулалт хийж байгаа. Мөн Хилийн цэргийн ерөнхий газартай хамтран ажиллаж байгаа. Хилийн бүсэд оруулах малын тоог орон нутагтай хамтраад ямар нэгэн хүндрэл гаргахгүйгээр зохион байгуулж байгаа. Энд бас хилийн бүс рүү нэлээн гол мал шилжинэ.

Мөн отрын 9 бүс нутагт 900 мянган толгой мал хүлээж авах бэлэн буюу бэлчээрийн даацтай гэсэн судалгаанууд гарсан.

Тэгэхээр байгаа нөөц бололцоо, төсөв санхүүгийн хүрээнд авах ёстой арга хэмжээнүүд үндсэндээ авагдаад бэлтгэл ажил үндсэндээ дууссан л гэж ойлгоорой.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариултаа авч дууслаа.

Санал хураалт явуулъя. Нийтдээ 11 зарчмын зөрүүтэй санал байгаа. Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Хүнсний болон үрийн буудайн нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, эргэлтийн хөрөнгийн сантай болгоход зориулсан татаасыг **23,000.0 сая** төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу.

Ш.Бямбасүрэн гишүүн. Дараа нь сайдууд хариулъя. Ш.Бямбасүрэн гишүүн.

Ш.Бямбасүрэн: Өнөөдөр нийгэмд маш том асуудал үүсчхээд эмч, багш нар маань ажил хаялт хаяад, долоо хоног ч яах вэ амралтын өдрүүд байна. Ирэх долоо хоногоос маш хүнд асуудлууд гарахаар байна.

Тэгэхээр бид тулгамдаж байгаа асуудлаа яаралтай шийдэхийн тулд 3 гишүүн нийлээд нийт 22 зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм. Тэгээд эндээс дандаа хасах санал байгаа. Өөр ямар нэгэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх төсөв дээр нэмэх байхгүй. Хэмнэлт хийх зорилалттай.

Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй 8 санал байгаа. Тэгээд гаргаж байгаа саналууд нь үндсэндээ аягүй хэрэгтэй юмыг хасах гэж байгаа юм шиг л харах байх л даа. Гэхдээ бид ер нь олон жил татаас гэдэг юмаараа чөлөөт зах зээлээ боомилж байгаа юм.

Хөтөлбөрүүд хэзээ дуусах нь тодорхойгүй. Хэзээ өөрөө өөрийгөө аваад явах бодитой тийм юу нь тодорхойгүйгээр хөтөлбөрүүдийг олон жил хэрэгжүүлж явж байгаа юм.

Зах зээлийнхээ зарчмаар шинэ тоглогч зах зээл рүү орох тийм боломж бололцоо бараг хүнд болсон. Яагаад гэвэл хэдэн цөөхөн компаниуд яг татаасыг авдаг. Тэгээд цаашдаа бид салбараа дэмжиж байгаа юм шиг хэр нь ээ урт хугацаандаа бид хорлоод байгаа бодлого яваад байгаа юм.

Тэгэхээр ер нь өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн татаасыг бид үр дүнг нь эргэж хараад тэгээд ахиад эргээд ярилцах ёстой юм биш үү гэсэн үндсэн дээрээс эдгээр саналуудыг гаргаж байгаа юм.

Дараа нь тэр “Шинэ хоршоо”-г нь яг тэр санал хураах үед нь дараа нь явъя. Үндсэндээ дараах гаргаж байгаа саналууд яг зах зээлийнхээ зарчмаасаа бид ухраад яваад байгаа. Хүнс чухал гэдгийг маш сайн ойлгож байгаа. Гэхдээ бид үүнийг ер нь цаашдаа ер нь яг эдийн засгийнх нь зарчмаараа өөрсдөө хувийн хэвшил нь аваад явдаг юм руу бид ер нь хэзээ явдаг болох вэ? Үүнийгээ бид эргэж харсны дараа үүнийгээ ярья л гэсэн агуулгаар оруулж байгаа юм. Тэгээд ямар нэгэн байдлаар төсөвт өртөг нэмэгдүүлэх юм бол байхгүй. Зөвхөн хэмнэлт хийх, тэгээд тулгамдаж байгаа асуудлаа шийдэх зорилгоор эдгээр асуудлуудыг оруулж байгаа юм. Тэгээд гишүүдийгээ дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Ш.Бямбасүрэн ахын дүү энэ чинь Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолтой хуульчлагдсан зардлууд байхгүй юу. Хугацаатай.

2028 онд хамгийн цаад тал нь хэрэгжээд дуусах юм. Үр дүнг энд байгаа бүх Их Хурлын бүх гишүүд тойрогтоо очиж ярих учиртай ийм л Их Хурлын бодлого.

Тодорхой 19 нэр төрлийн бараан дээр л төрөлжиж байгаа. Анхаарч байгаа юм. Ковидын сургамж. Ковид ахиад нэг сар бид хөл хорио үргэлжлэхэд Монгол Улс картын бараанд орохоос аргагүй байсан. Ийм хүнд байдал дээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дүгнэлт хийгээд хөтөлбөрүүдийг гаргаж ирсэн байхгүй юу.

Дотоодын үйлдвэрлэлээр хангах ёстой 19 нэр төрлийн бараа үйлдвэрлэлийг эх орондоо бүтээе, бий болгоё гэж. Хүнсний аюулгүй байдлын асуудал байхгүй юу.

Нөгөө талаар бид нийт 430-аад төрлийн хүнс, барааны хэрэглээ байгаа. Дундаж Монгол Улсын иргэн 430-аад төрлийн юм хэрэглэж байгаа. Үүнээс сонгож авсан 19 нэр төрлийн бараа, хүнс боловсруулах бодлого гарч ирсэн. Ингэж явж байгаа учиртай нь шүү дээ. 2028 он гээд дуусна. Энэ бол бидний хамтын ажиллагааны үр дүн байх ёстой.

Үр дүн гарч байна. Хэзээ ч дотоодын нийт бүтээгдэхүүнд томоохон хувь эзэлдэг байсан хөдөө аж ахуйн салбар дангаараа жилийн 5.6 хувийн өсөлтийн 3.6-г дангаараа бүрдүүлээд ороод ирлээ. 44 мянган ажлын байр шинээр бий болгоод ирлээ.

Ялангуяа уул уурхайгаас хамааралтай манай эдийн засаг сая уул уурхайн мөчлөг уналтад ороод ирэхэд сөрж хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбар чинь босож ирж байна шүү дээ.

Хамгийн олон хүнийг орон нутагт нь ажилтай, амьдралтай байлгаж байна. Хамгийн олон мянган ажлын байрыг хангаж байна. Ийм салбараа бид уул уурхайгаас ангид эдийн засгийг босгох гол бодлого маань шүү дээ. Ингэж ойлгож хандаж ажлын ард гармаар байна.

Түүнээс ингэж үгүйсгээд, үг хэлэхдээ салбарыг үгүйсгээд, бодлогыг үгүйсгээд өөрийнхөө мэдээллийг үнэн зөв юм шиг хандаад байхаа ер нь жоохон болимоор байна. Цаана нь ийм нарийн бодлого учир шалтгаан үүсэж байгаа гэдгийг, үр дүнгүүд гарч байгаа гэдгийг.

Зөвхөн экспорт гэхэд энэ жил манай ноолуур чинь 404 сая долларын экспорт байсан бол 600 сая доллар луу очих нь байна. Бид 10, 20 саяас хэтэрч үзээгүй махны экспорт маань 3 жил дараалан 300 сая долларын экспорт хийх гэж байна шүү дээ. Энэ чинь цаанаа малчин мал аж ахуйг ямар их том дэмжиж байгаа хөшүүрэг болж байгаа зүйл билээ.

Үр тариа, газар тариалангийн салбар чинь экспорт гаргадаг болж хувирч байна. Олон олон үйлдвэрүүд шинээр нээгдлээ, өргөтгөлөө. Энэ хөтөлбөр чинь хөдлөөд эхэлсэн байхгүй юу даа.

Дөнгөж хөдлөөд эхлэнгүүт нь суурийг нь цохих, зогсоох, энэ итгэл хүсэл зоригийг мохоох юмыг бид ерөөсөө ярьж болохгүй. Аль болох л дэмжээд хувийн хэвшлийн хийж байгаа ажил.

Манай яамны бүх бодлого байна шүү дээ. Бүх төсвийнхөө бараг 99 хувийг хувийн хэвшилдээ бодлогын дэмжлэг болгож өгч байгаа. Хуучин шиг сайд аваад өөрөө дур мэдэн зарцуулдаг, энд тэндээ хуваарилдаг зүйл огт үгүй. Яавал

төгрөгийг 10 төгрөг болгох вэ гэдэг хөшүүргийн зарчмаар л арилжааны банк, Монголбанктайгаа хамтраад бодлогууд хэрэгжүүлээд яваад байна шүү дээ.

Тэр талаас нь гишүүд маань ойлгоод яагаад ч хасаж болохгүй. Сүүг бол яагаад ч хасаж болохгүй. Ногоогоо яагаад ч хасаж болохгүй. Үрээ хасна гэдэг чинь байж боломгүй монгол хүний сэтгэлээс гарч боломгүй зүйл шүү дээ. Үрээ идэхээр үнээгээ ид гэдэг.

Ирэх онд тарих нөөцлөх үрээ өнөөдөр байхгүй болгоё гэж байна. Үүнийг чинь бодлогын хувьд энэ жилийн ургацаас аль хэдийн аваад бэлдээд хураагаад зооринд хадгалаад хүлээгээд авсан байхгүй юу. Он гараад мөнгийг нь өгдөг.

Ийм мэтийн салбарын асуудлыг мэдэхгүйгээр хандаж ерөөсөө болохгүй. Энэ болгон чинь л дараа нь залруулшгүй том алдаа хохирол үзүүлээд байгаа нь саяын тэр улаан буудайтай холбоотой 150 мянган тонныг бид Оросоос гуйх хэмжээнд очтолоо сая бодлогын алдаа гарлаа гарлаа шүү дээ. Дотооддоо хангаж байсан зүйлээ унагааж болохгүй.

Р.Сэддорж: Түрүүний уншсанаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

19 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд инновац нэвтрүүлэх, тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх, бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, бэлчээрийн ашиглалт, хамгааллыг сайжруулах, отрын нөөц бэлчээр, усан хангамж, өвс тэжээлийн нөөц, хангамжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулсан татаасыг **24,300.0 сая** төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу.

Санал хураалт. /алх цохив/

4 гишүүн дэмжиж, 19 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Сүүний урамшууллын татаасыг **13,900.0 сая** төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу.

Тайлбар Ш.Бямбасүрэн гишүүн.

Ш.Бямбасүрэн: Сүүний урамшууллын татаасыг хасах саналаа татаад авъя. Санал хураалгахгүй.

4 дэх санал хураалт. Ш.Бямбасүрэн гишүүн саналаа татаж авсан байна.

4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Атрын 4 дүгээр аянд зориулсан Хүнсний ногооны урамшууллын татаасыг 11,500.0 сая төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу.

Санал хураалт. /алх цохив/

3 гишүүн дэмжиж, 14.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

5.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь цагаан алт хөтөлбөрийн ноосын урамшууллын татаасыг 15,600.0 сая төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Санал хураалт. /алх цохив/

4.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

6.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь арьс ширний урамшууллын татаасыг 6,200.0 сая төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Санал хураалт. /алх цохив/

14.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

7.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь цагаан алт хөтөлбөрийн “Бусад арга хэмжээн”-нд тусгагдсан санхүүжилтийг 600.0 сая төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй. 5 гишүүн дэмжсэн байна.

8.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн хүүгийн дэмжлэгийг **608,900.0 сая /133,954.0/ төгрөгөөр** бууруулах.

Тайлбар сонсьё. Хоёр тоо байгаа учраас.

Нэг нь 133 тэрбум 954 гээд бичсэн байна. Тайлбарыг нь сонсьё. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу гэсэн байна.

Ш.Бямбасүрэн гишүүнд тайлбар өгөөдөх.

Ш.Бямбасүрэн: Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн 4.2.2 дээр салбарын урсгал зардал дахь бусад салбарын урсгал зардал дахь гээд 10-т нь хөдөө аж ахуйн салбарыг дэмжих арга хэмжээ “Шинэ хоршоо”, “Чинээлэг малчин” хөдөлгөөн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн дэмжлэг гээд 608 тэрбум төгрөг гээд туссан байгаа юм.

Тэгэхээр үүнийг л хасъя гэдэг байдлаар оруулж байгаа юм.

Тэгээд энэ дээр нь давхар хүүгийн татаас гээд тусдаа 100 гаруй тэрбум яваад байгаа юм.

Тэгэхээр ийм байдлаар томьёоллоо оруулсан байгаа юм.

“Шинэ хоршоо” хөдөлгөөн бол 2024 онд гэнэт хэрэгжээд эхэлсэн. Төсөвт ямар нэгэн юм байхгүйгээр гэнэт эхэлсэн. Сонгуулийн жилд угтаад ер нь санал худалдан авах зорилгоор гаргасан хөдөлгөөн. Үүнийг бид өөрсдийгөө хуураад нэмэр байхгүй.

Энэ “Шинэ хоршоо”-г бид маш амжилттай хэрэгжиж байгаа маш олон хоршоод байгуулагдаад явж байгаа гээд тайлбар хэлээд байгаа юм. Гэтэл би бас орон нутгаас сонгогдсон тойргийн гишүүн хүн. Яг тэр орон нутагт зүгээр овсгоотой нь баахан иргэний үнэмлэх цуглуулж авчраад баахан хувьдаа хөнгөлөлттэй зээл аваад өөр юм хийгээд яваад байгаа юм. Бид үр дүнг ярих ёстой. Тэгэхгүй бол бид хэдэн хоршоод бий болсон гээд хоршооныхоо тоогоор бид өөрсдийгөө хуураад байж болохгүй.

Тэгэхээр бид “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг бүр ахиж эргэж харах шаардлагатай.

Тийм учраас үүнийг бүрэн зогсооё гэж байгаа юм. Би бүх хоршоодыг чадахгүй байна гэж хэлж байгаа юм биш. Энд ганц нэг сайн явж байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлээд зах зээл дээр гаргаад борлуулалт хийж байгаа

хоршоод байна. Гэхдээ энэ бол бараг дийлэнх нь яг үндсэн үүргээрээ явж чадахгүй байгаа.

Зээлийн эргэн төлөлт нь маш сайн гэж байгаа юм. Энэ сайн байхаас яадаг юм. Тэртээ тэргүй төрөөс татаасыг нь өгч байгаа юм чинь тэд нар чинь өөр ямар нэгэн юм руу хийгээд энэ мөнгө чинь буцаагаад төлөгдөж байгаа байхгүй юу.

Тэгэхээр эргэн төлөлт сайтай гээд яриад бид өөрсдийгөө хуураад байдаг. Эцсийн дүндээ хожиж байгаа нь банкууд л байгаа шүү дээ. Банкуудад ямар ч эрсдэлгүй сайхан зээлүүд гараад явчхаж байгаа.

Тийм учраас “Шинэ хоршоо”-г бид болих, хасах санал гаргаж байгаа юм.

Тэгэхээр үүнийг эргэж хараад үр дүнг нь бид эхлээд хэмжих ёстой юм билээ. Тэгэхгүй бол үр дүнгүй баахан юмнууд яваад байгаа шүү. Тэгээд хамгийн аймшигтай нь эцэст нь хоршоод чинь дараа нь зээлийн эргэн төлөлт дээрээ бөөн маргаан болоод баахан малчид хоорондоо муудалцсан тийм нөхцөл байдал руу л аваачих юм байна гэж би дүгнэж байгаа юм. Яагаад гэвэл хэн нэгэн нь нөгөөдүүлийнхээ нэрийг бариад баахан хар дансанд бүртгүүлэх тийм нөхцөл байдал бий болоод байгаа юм.

Тэгээд би ахиад ганцхан минут авч болох уу?

Б.Бейсен: С.Амарсайхан Шадар сайд тайлбар.

С.Амарсайхан: Би гишүүдийн гаргаж байгаа багш, эмч нарын цалин хөлс нэмэх тухай асуудлыг дэмжиж байгаа. Яагаад гэвэл ирээдүйн оюуны бөгөөд эрүүл мэндийн хоёр хүч улс оронд байж улс орон хөгждөг, урагшилдаг ийм жамтай.

Багшийн цалин гэдэг бол тоо биш. Энэ багшийн оюуны бүтээмж, сурагч, оюутан залуучуудын ирээдүйн хариуцлагатай иргэн бүтээлч хандлагыг бий болгох асуудал.

Эрүүл мэнд эмч, сувилагч эмч нарын цалин. Энэ бас бид эрүүл байж цаашаа Монгол Улс хөгжлийн чанар өрсөлдөх чадвар өөрөө урагшилна дээшилнэ.

Тэгэхээр аль альныг нь дэмжиж байгаа. Гэхдээ хоршооны асуудлыг энэ далим дундуур үгүйсгэж болохгүй. Малчдын хөдөлмөрийг дэмжлээ гэх нэг том бодлого. Тэгээд Монгол Улс өөрөө өргөн уудам газар нутагтай, цөөн хүн амтай. Малчид чинь өөрөө баруун, зүүн хязгаар нутагт эх орныхоо өмнөөс, ард түмнийхээ өмнөөс газар нутгаа харж хандаж, хамгаалж, хаврын шуурга, өвлийн

хүйтэн, намрын сэрүүн бороо, тэгээд зуны халуунд хүн амаа тэжээх гэж борви бохисхийхгүй зүтгэж байгаа ард түмэн. Түүнээс гадна хамгийн чухал нь бидний язгуур соёл, үндэсний өв уламжлалыг тээж яваа амьд өв сан болсон хүмүүс.

Малчидгүйгээр, таван хошуу малгүйгээр энд өчнөөн сайхан барилгад өчнөөн сайхан дэд бүтэц бариад бид монгол монголоороо байж чадахгүй.

Газар нутгийн 76 хувь нь цөлжсөн байна. Одоо хөдөө газар “Шинэ хоршоо”-ны судалгаа ч байж байна. Бид нарын өмнө байгаа мэдээлэл ч байж байна.

200 мянган малчин өрх байна. Одоо мал малладаг хүн олдохоо больсон. Энэ байдлаараа бид “Шинэ хоршоо” гэдэг Засгийн газрын уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, малчид иргэдээ хамгаалах бодлогыг явуулж чадахгүй бол 10-хан жилийн дараа гэхэд бид мал хамар хатгах өвсгүй, монголчууд бид өөрсдөө идэх махгүй, гадагшаа экспортлох биш гаднаас импортолдог улс болно.

Малчид чинь өөрсдийгөө ажлын байраар хангаж байгаа юм. Өрөөл бусдыг ажлын байраар хангаж байгаа юм. Хот суурин газрын бидний ширээн дээр ирдэг атга ааруул, килограмм махыг бүтээх гэж хамаг амьдралаа зориулж байгаа хүмүүс.

Тэгэхээр багш, эмч нарынхаа цалинг ч нэмэх ёстой. “Шинэ хоршоо” хөтөлбөрийг ч явуулах ёстой. Ингэж байж бид эрүүл оюунлаг байна. “Шинэ хоршоо” хөтөлбөр чинь эмч нарын цалинг нэмнэ гэдэгтэй адилхан эрүүл Монгол хүн байх тухай асуудал байхгүй юу. Мал эрүүл байж байж хүн эрүүл байна. Мах эрүүл байж байж бидний хүнс эрүүл байна.

Тэгэхээр оюунлаг эрүүл байх асуудлуудаа бид ганцхан хөтөлбөр асуудлаар биш цогцоор нь авч үзэж байж үндэсний хэмжээний стратеги гэж харж байж үүнийг хөгжүүлэхгүй бол нэгийг нь хасахын тулд, нэмэхийн тулд нөгөөхийг нь хасдаг. Эцэстээ бүгдээрээ улс орныхоо хувь заяа үндэстэн оршин тогтнох эсэх асуудлаараа золиос гаргаж болохгүй.

Тэгэхээр саналуудаа хэдүүлээ эргэж харах ёстой. Багш, эмч нарынхаа цалинг өөр эх үүсвэрээс энэ төсөв дээр тавьж нэмэх ёстой. Тэгээд хүүхдээ ч баталгаатай сургая. Багш нараа ч идэвхтэй бөгөөд оюуны үнэлэмжийг нь дээшлүүлэе. Эмч, сувилагч, эрүүл мэндийн салбарын бүх ажилтнуудаа эрүүл Монгол өрсөлдөх чадвартай, амьдралын чанартай Монгол Улс байх тал дээр нь бүгдийг нь дэмжиж ажиллацгаая гэдэг саналыг хэлж байгаа юм.

Б.Бейсен: Санал хураалт.

3 хүн дэмжсэн санал өгч, нийтдээ 85.7 хувиар дэмжигдээгүй байна.

9.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 9,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Онги-Цагаан бургастай төсөл, төслийн ТЭЗҮ, зураг төсөв, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 44,490.0 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн.

Тайлбар Л.Мөнхбаясгалан.

Л.Мөнхбаясгалан: Говийг усжуулах “Орхон-Онги”, “Хэрлэн-Тооно” усны мега төслүүд гэж яриад бид жил гаруй боллоо.

2025 оны төсөвт юу ч тусгагдаагүй. Энэ удаа бид ямар хуулийг баримталж байна вэ гэвэл Төсвийн тухай хууль. Төсвийн тухай хуулийн 5.1 дээр төсөв нь улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална гэж. Хариуцлагатай байх ёстой. Улсын хөгжлийн төлөвлөгөөнд суурилсан байх ёстой гэж байгаа юм.

Тэгэхээр энд Монгол Улсын 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2026 оны хөгжлийн төлөвлөгөө, Улсын Их Хурлын 48 дугаар тогтоолтой.

Энд говийг усжуулах төслийн нэгж дээр “Онги-Цагаанбургастай” төслийн ТЭЗҮ, зураг төслийг хийхэд 44.0 тэрбум төгрөг төлөвлөсөн. Үүнээсээ 13.5 тэрбум төгрөг төлөвлөсөн байсныг 2026 оны улсын төсөвт юу ч орж ирээгүй.

Тийм учраас Эдийн засаг, хөгжлийн яаман дээр байгаа зураг төсөл, ТЭЗҮ гэсэн зориулалттай 40.0 тэрбум төгрөгөөс 9 тэрбум төгрөгийг бууруулж “Онги-Цагаанбургастай” төслийн ТЭЗҮ, зураг төсөв дээр шилжүүлэх зарчмын зөрүүтэй саналыг гаргасан.

Холбогдох сайдтай Эдийн засаг, хөгжлийн сайдтай ярилцаж зөвшилцөлд хүрсэн. Үүнээс өмнө Төрийн ордонд 2 удаа энэ төсвийн тухай, Говийн цөлжилттэй тэмцэх тухай, усны ТЭЗҮ-гийн тухай бид 2 удаа хэлэлцүүлэг хийсэн. Хамгийн сүүлд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр хийсэн.

Тийм учраас энэ дээр аль аль нь ойлголцолд хүрсэн.

- ▶ Сангийн яам мэдэж байгаа.
- ▶ Эдийн засаг, хөгжлийн яам мэдэж байгаа.
- ▶ Байгаль орчин уур амьсгалтын өөрчлөлтийн яам мэдэж байгаа.

Тийм учраас эрхэм гишүүд ээ, жил болгон улсад

- 1.7 их наядын төсөв төвлөрүүлж байгаа Өмнөговь аймаг,
- 10 гаруй тэрбум төгрөг төвлөрүүлж байгаа Дорноговь аймаг,
- зөвхөн Замын-Үүд сум гэхэд 200 гаруй тэрбум төгрөгийг төсөвт оруулдаг

говийн бүсийн “Онги-Цагаанбургастай” төслийн ТЭЗҮ-г дэмжиж 9 тэрбум төгрөгөөр төслийн арга хэмжээг санхүүжүүлэх зарчмын зөрүүтэй саналыг дэмжиж өгнө үү.

Үүнийг говийн бүсийн гишүүд Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн миний бие гаргаж байна. Н.Наранбаатар гишүүн. Уучлаарай.

Б.Бейсен: Санал хураалт. /алх цохив/

16 гишүүн дэмжиж, 76.2 хувиар дэмжигдлээ.

10.Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багц дахь Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт хөтөлбөрийн зардлыг **856.3 тэрбум** төгрөгөөр бууруулж, Говийг усжуулах судалгааны нэгжийн урсгал зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн.

Санал хураалт. /алх цохив/

16 гишүүн дэмжиж, 76.2 хувиар дэмжигдлээ.

11.Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багц дахь Агаар орчныг бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг **78,530.8 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, энэ эх үүсвэрийг дараах төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг бууруулж болон төслөөс хасаж тооцох. Үүнд:

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2600100054 төслийн кодтой, Ерөнхийлөгчийн Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар,

Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **500.0 сая** төгрөг гэсэн төсөл арга хэмжээг хасах,

- УТ2600200018 төслийн кодтой, Улсын Их Хурлын Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **3,637.5 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
 - УТ2601200838 төслийн кодтой Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,365.4 сая** төгрөг, сахүүжих дүн **1,064.5 сая** төгрөг гэсэн төсөл, арга төсөл арга хэмжээг хасах,
 - УТ2601200355 төслийн кодтой, Цагдаагийн газрын барилга /Булган, Булган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 5,353.6 сая төгрөг, санхүүжих дүн **1,606.1 сая** төгрөг гэсэн төсөл арга хэмжээг хасах,
 - УТ2601501976 төслийн кодтой, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **9,237.6 сая** төгрөг, санхүүжих дүн **2,771.3 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
 - УТ2601501953 төслийн кодтой, Хангайн бүсийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,126.8 сая** төгрөг, санхүүжих дүн **1,407.1 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
 - УТ2602800888 төслийн кодтой, Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **60,156.2 сая** төгрөг, санхүүжих дүн **18,046.9 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
 - УТ2602800636 төслийн кодтой, Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архустын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **170,899.7 сая** төгрөг, санхүүжих дүн **25,635.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
 - УТ2603400215 төслийн кодтой, Аялал жуулчлал, спортын цогцолборын
-

барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **8,396.8 сая** төгрөг, санхүүжих дүн **3,778.6 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,

- УТ2603400522 төслийн кодтой, спорт заалын барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,103.4 сая** төгрөг, санхүүжих дүн **1,396.6 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2603400239 төслийн кодтой, Спорт заалын барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,156.8 сая** төгрөг, санхүүжих дүн **970.6 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2603400052 төслийн кодтой, Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **6,728.8 сая** төгрөг, санхүүжих дүн **2,018.7 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2602900939 төслийн кодтой, Инженерийн шугам сүлжээ /Ховд, Дарви сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,792.7 сая** төгрөг, санхүүжих дүн **1,256.8 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2602900037 төслийн кодтой, Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, далан суваг /Хөвсгөл, Их-Уул сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,652.9 сая** төгрөг, санхүүжих дүн **1,643.9 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2602900572 төслийн кодтой, Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **10,407.8 сая** төгрөг, санхүүжих дүн **3,122.4 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2602900674 төслийн кодтой, Үерийн хамгаалалтын далангийн байгууламж, 5 км /Завхан, Улиастай сум, Жаргалант, Чигэстэй баг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **7,829.8 сая** төгрөг, санхүүжих дүн **3,523.4 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2606700065 төслийн кодтой, Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **14,368.5 сая** төгрөг, санхүүжих дүн **4,310.6 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах,
- УТ2603300016 төслийн кодтой, Авлигатай тэмцэх газарын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо/, хэрэгжих

хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **239.5 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах,

- УТ2601300963 төслийн кодтой, Цаг уурын харуулын барилга /Баян-Өлгий, Булган, Увс, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **388.3** сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах,
- УТ2601501638 төслийн кодтой, Дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Халзан сум, 1 дүгээр баг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,695.5 сая төгрөг, санхүүжих дүн **1,213.0 сая** төгрөг гэсэн төсөл арга хэмжээг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц гэсэн байна.

Г.Лувсанжамц гишүүн тайлбар хэлье.

Г.Лувсанжамц: Байгаль орчны байнгын хорооны эрхэм гишүүдийн оройн мэндийг хүргэе.

Энэ дээр ийм санал оруулж байгаа шалтгаан нь ирэх жил улсын төсөв дээр нийслэл гэлтгүй Дархан, Эрдэнэт хот, аймгийн төвүүдийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээн дээр ямар ч төсөв байхгүй байгаа.

Тэгэхээр энэ дээрээ Байгаль орчны яамнаас өгдөг ногоон зээлийн хүүгийн татаасын эх үүсвэр дээр Байгаль орчны сайдын багц руу энэ дээр дурдагдсан 20 төсөл, арга хэмжээний эх үүсвэрийг нь шилжүүлбэе гэсэн тийм санал гаргаж байгаа.

Үндэслэл нь энэ 20 төслийн 18 нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөн дээр тусаагүй. Сүүлийн 2 төслийн хувьд ТЭЗҮ, зураг төсөл байхгүй.

Тэгэхээр өнгөрсөн хаврын чуулганаар хөгжлийн төлөвлөгөө болон түүндээ тусгах, дээрээс нь нэмээд ТЭЗҮ болон зураг төслийн ажлаа хийгээгүй төсөл, арга хэмжээнүүдийг төдий хэмжээгээр нь бууруулаад, энэ дээрээс хассан бүх эх үүсвэрийгээ Байгаль орчны яамны төсөв рүү оруулъя гэж байгаа.

Оруулах гэж байгаа шалтгаан нь миний зүгээс хаврын чуулганаар 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний 2 дугаар хавсралтын 3.10.2-т агаарын бохирдлыг бууруулах зорилгоор ногоон зээлийн дэмжлэг үзүүлэх гэсэн саналыг оруулаад нэгдсэн чуулган дээр Та бүхэн дэмжиж өгсөн.

Тэгэхээр үүнийхээ эх үүсвэрийг нь төсөв дээрээ тавья гэсэн саналыг оруулж байгаа юм. Дэмжиж өгөхийг хүсье. Асуулт байвал бас хариулъя.

Б.Бейсен: Санал хураалт. /алх цохив/

7 гишүүн санал өгч, 33.3 хувиар дэмжигдсэнгүй. Санал хураалт дууслаа.

Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал Төсвийн байнгын хороонд танилцуулна.

Гурав дахь хэлэлцлийг явуулж дууслаа. /алх цохив/

Одоо 2 санал хураалт. Гишүүд ээ. Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Байгал орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, үндэсний удирдлагын байнгын хороонд шилжүүлсэн.

Өнөөдөр уг хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг Та бүхэнд танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы

нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Уянга Монгол Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Н.Алтаншагай	Улсын Их Хурлын гишүүн
П.Батчимэг	Улсын Их Хурлын гишүүн
Б.Бат-Эрдэнэ	Улсын Их Хурлын гишүүн
Ц.Идэрбат	Улсын Их Хурлын гишүүн
С.Замира	Улсын Их Хурлын гишүүн
Ц.Мөнхбат	Улсын Их Хурлын гишүүн
Б.Мөнхсоёл	Улсын Их Хурлын гишүүн
Ц.Одонтуяа	Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэг зөвшөөрсүгэй.

Санал хураалт явуулъя. Ажлын хэсэг батлах. Санал хураалт. /алх цохив/

13 гишүүн дэмжиж, 61.9 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Дараагийн асуудлаар “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Ажлын хэсгийн удирдамж батлах тухай/

Байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлоор ахлуулсан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийг төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу Байнгын хорооны тогтоолоор батлахаар заасны дагуу өнөөдөр танилцуулж байна.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдон асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүн байхгүй байна. /алх цохив/

“Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдэг санал хураалтаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Ажлын хэсгийн удирдамжийг 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүдэд баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 00 минут үргэлжилж, 17 цаг 59 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД